

Монголбанкны Ерөнхийлөгч, Үндэсний статистикийн  
хорооны даргын 20... оны ... сарын ... -ны өдрийн  
... дугаар хамтарсан тушаалын **ХАВСРАЛТ**

# **МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙГ БОЛОВСРУУЛАХАРГАЧЛАЛ**

(3 дахь өөрчлөлт)

Улаанбаатар хот  
2012 оны 3 дугаар сар

## Агуулга

<b>1. Ерөнхий зүйл.....</b>	<b>3</b>
1.1 Нийтлэг үндэслэл.....	3
1.2 Гүйлгээг бүртгэх зарчим.....	5
1.3 Ажил, гүйлгээ, актив, пассивын үлдэгдлийн үнэлгээ .....	6
1.4 Тэнцэлд ашиглагдах ангилал .....	6
1.5 Алдаа ба орхигдуулга .....	6
1.6 Тайлангийн хугацаа .....	7
1.7 Төлбөрийн тэнцлийн үзүүлэлт.....	7
<b>2. Урсгал данс.....</b>	<b>7</b>
2.1 Бараа болон үйлчилгээний худалдаа .....	8
2.1.1 Барааны данс .....	8
2.1.2 Үйлчилгээ .....	10
2.2 Анхдагч орлого .....	23
2.3 Хоёрдогч орлого .....	28
<b>3. Хөрөнгийн данс.....</b>	<b>31</b>
3.1 Хөрөнгийн шилжүүлэг .....	31
3.2 Үйлдвэрлэгдэхгүй, санхүүгийн бус хөрөнгө .....	34
<b>4. Санхүүгийн данс .....</b>	<b>34</b>
4.1 Шууд хөрөнгө оруулалт.....	35
4.1.1 Гадаадад оруулсан шууд хөрөнгө оруулалт (Актив) .....	35
4.1.2 Гадаадаас орсон шууд хөрөнгө оруулалт (Пассив).....	36
4.2 Багцын хөрөнгө оруулалт .....	37
4.3 Санхүүгийн үүсмэл хэрэгсэл болон албан хаагчдын үнэт цаасны опцион ...	39
4.4 Бусад хөрөнгө оруулалт.....	41
4.5 Гадаад валютын албан нөөц .....	43
<b>5. Үндэсний тооцооны систем ба төлбөрийн тэнцэл .....</b>	<b>44</b>

## 1. Ерөнхий зүйл

### 1.1 Нийтлэг үндэслэл

1. Энэхүү аргачлалын зорилго нь Монгол Улсын төлбөрийн тэнцлийн статистикийн үзүүлэлтийг тодорхойлж, тэнцлийг боловсруулахад оршино.
2. Монгол Улсын төлбөрийн тэнцэл нь Монгол Улсаас гадаад орнуудтай тайлант хугацаанд гадаад худалдаа, эдийн засгийн бусад харилцааны талаарх хийсэн төлбөр тооцооны гүйлгээг нэгтгэн харуулдаг статистик нэгтгэл юм.
3. Төлбөрийн тэнцлийг макро эдийн засгийн бодлого боловсруулах, барааны худалдаа, шууд хөрөнгө оруулалтын уялдаа, олон улсын үйлчилгээний гадаад худалдааны төлөв байдал, гадаад өрийн асуудал зэрэгт дүн шинжилгээ хийхэд ашиглана.
4. Энэхүү аргачлалыг төлбөрийн тэнцлийг боловсруулах ОУВС-ийн 6-р гарын авлагад нийцүүлэн боловсруулав.
5. Энэхүү аргачлалд дурдагдах нэр томъёог дараах утгаар ойлгож хэрэглэнэ:
  - 4.1 Төлбөрийн тэнцэл бол тодорхой хугацаанд эдийн засгийн харьяат болон эдийн засгийн харьяат бусын хооронд хийсэн худалдаа, үйлчилгээ, орлого, урсгал шилжүүлэг, санхүүгийн болон хөрөнгийн урсгалыг системчлэн нэгтгэсэн статистикийн тайлан юм.
  - 4.2 Эдийн засгийн харьяат нэгж:
    - 4.2.1 Эдийн засгийн нутаг дэвсгэрт Монгол Улсын Засгийн газрын хяналтын дор хүн ам чөлөөтэй зорчин, бараа, үйлчилгээ, хөрөнгөө гүйлгээнд чөлөөтэй оруулж болох нутаг дэвсгэрийг; тухайлбал: (а) газар нутаг, агаарын орон зай болон загас агнуур, шатахуун, эрдэс баялаг ашиглах эрх бүхий гол ус; (б) гадаад орнуудад байгаа тухайн улсын тусгай эзэмшлийн нутаг дэвсгэр; (в) бусад улсын нутаг дэвсгэр дээр байрлах бөгөөд байршиж буй нутаг дэвсгэрийн Засгийн газрын албан ёсны зөвшөөрлөөр дипломат, цэрэг, шинжлэх ухаан эсвэл бусад зорилгоор Засгийн газраас ашиглах тодорхой заагтай нутаг дэвсгэр (элчин сайдын яам, консулын газар, цэргийн бааз, мэдээллийн эсвэл цагаачлалын алба, тусламжийн агентлаг, дипломатын халдашгүй эрх бүхий төв банкны төлөөлөгчийн газар гэх мэт)-ийг хамааруулна. Эдийн засгийн нутаг дэвсгэр нь байршлын болон хуулийн хязгаарлах эрхийн хэмжүүртэй байна.
    - 4.2.2 “Эдийн засгийн зонхилох сонирхлын төв” нь эдийн засгийн нэгж нь хязгааргүйгээр эсвэл хязгаартай боловч удаан хугацаанд (ихэвчлэн нэг ба түүнээс дээш жил) эдийн засгийн үйл ажиллагаа болон ажил гүйлгээнд оролцох болон оролцох гэж байгаа эдийн засгийн зарим нутаг дэвсгэрт орон байртай, үйлдвэрлэлийн газар эрхлэхийг;
    - 4.2.3 “Эдийн засгийн харьяат (цаашид харьяат)” гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дээр оршин сууж байгаа Монгол улсын иргэд, гадаад оронд 1 жил хүртэлх хугацаагаар түр оршин сууж байгаа Монгол Улсын иргэд, Монгол улсын нутаг дэвсгэр дээр 1 жилээс дээш хугацаагаар оршин сууж байгаа гадаадын иргэд, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага, тэдгээрийн салбар, төлөөлөгчийн газар, Монгол

Улсаас гадаад орнуудад суугаа элчин сайдын яам, консулын болон байнгын төлөөлөгчдийн газар, тэдгээрт ажилладаг Монгол Улсын иргэд, цэргийн албан хаагч гэр бүлийн гишүүдийн хамт, гадаад оронд сурч байгаа болон гадаадад урт, богино хугацаагаар эмчлүүлж байгаа Монгол Улсын иргэдийг;

4.2.4 Үйлдвэрийн газарт өөрийн хүчин чадлаараа бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэгч байгууллагын бүтэцтэй нэгжийг оруулна.

- Үйлдвэрийн газар нь байгууллагын бүтэцтэй нэгжийн хамгийн доод түвшний нэгдэл бөгөөд өөрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай бүхий л үүрэг хариуцлагаа бие даан хүлээж, шууд ба шууд биш байдлаар хяналт тавьж ажиллана.
- Үйлдвэрийн газар нь хоршоолсон корпораци, квази корпораци, ашгийн бус байгууллага эсвэл хоршоолоогүй үйлдвэрийн газар байж болно.
- “Хөдөлгөөнт тоног төхөөрөмжөөр үйл ажиллагаа явуулдаг нэгж” нь олон улсын ус, агаарын замд эсвэл бусад эдийн засагт үйл ажиллагаа явуулдаг байж болно. Энд төрийн далбаа түрээслэх үйл ажиллагаа багтана.

4.2.5 “Эдийн засгийн харьяат бус”(цаашид харьяат бус) гэж 4.2.3-т үл хамрагдах гадаад орны болон Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг ойлгоно.

4.3 Эдийн засгийн нэгж гэж өөрийн эрхийн хүрээнд актив эзэмших, пассив үүсгэх, эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох, бусад хуулийн этгээдтэй ажил, гүйлгээ хийх чадвар бүхий нэгж юм. Эдийн засгийн нэгж нь өрх, хуулийн этгээд субъект юм.

4.4 Хуулийн этгээд субъект гэж хуулиар зөвшөөрөгдсөн, хувь хүн, бусад субъектээс хараат бус, өмч эзэмшигчдийнхээ удирдлага хяналтанд ажилладаг нэгжийг хэлнэ.

4.5 “Бараа” гэж эдийн засгийн харьяат болон харьяат бусын хооронд өмчлөлшилжих боломж бүхий биет барааг;

4.6 “Үйлчилгээ” гэж үйлчлүүлэгч эсвэл бүтээгдэхүүний төлөв байдал, чанарыг өөрчлөн хувиргах үр дагавар бүхий үйл явцыг;

4.7 “Зах зээлийн үнэ” гэж ямар нэгэн зүйлийг борлуулах хүсэлтэй байгаа худалдаачдаас уг зүйлийг худалдан авахаар худалдан авагчдаас төлж буй мөнгөний тоо хэмжээг;

4.8 “ФОБ нөхцөлийн үнэ (хил хүртэлх бүх зардал шингэсэн)” гэж тухайн барааг нэгдсэн үнэлгээнд оруулсан үеийнх нь (экспортоор гаргасан орны эдийн засгийн гаалийн хил) зах зээлийн өртгийг; ФОБ үнэ нь СИФ үнээс экспортлогч (импортлогч) орны гаалийн хил болон импортлогч (экспортлогч) орны гаалийн хилийн хооронд гарах тээврийн зардал, даатгалын хураамжийг хассантай тэнцүү байна.

4.9 “СИФ нөхцөлийн үнэ” гэж импортын татвар болон тухайн улсын доторхи худалдаа, тээврийн нэмэгдэл ногдуулахаас өмнөх импортлогч улсын хил хүртэлх даатгал, ачаа тээврийн зардал нь ачуулсан барааны үнэд орсон, эсвэл эдийн засгийн харьяатад үзүүлсэн үйлчилгээний үнийг;

- 4.10“ДАФ/ДАТ нөхцөлийн үнэ” гэж экспортын барааг Монгол улсын хилийн боомт хүртэлх нөхцөлийн үнээр бүртгэнэ. ДАФ/ДАТ нөхцөлийн үнэд барааны үнэ, Монгол улсын хил хүртэлх тээвэр, даатгалын зардал орно.
- 4.11“Боомтод нийлүүлсэн бараа” гэж гадаад орны нисэх онгоц, галт тэргэнд нийлүүлсэн шатахуун, бусад материал болон татваргүй барааны дэлгүүрийн харьяат буст борлуулсан барааг;
- 4.12“Шилжин суугчид” гэж гадаад оронд сурах, эмчлүүлэх, аялах зорилгоор зорчсон зорчигчдоос бусад нэг жил, түүнээс дээш хугацаагаар явсан иргэдийг;
- 4.13“Шилжин суугчдын шилжүүлэг” гэж гадаад орон руу амьдрахаар явах үедээ шилжүүлсэн гэр ахуй, хувийн хэрэглээний зүйлс, хөдлөх хөрөнгө (автомашин, тоног, төхөөрөмж гэх мэт), санхүүгийн хөрөнгийг (харилцах, хадгаламжийн дансны үлдэгдэл, үнэт цаас гэх мэт) ойлгоно.
- 4.14“Мөнгөжөөгүй алт” гэж нунтаг болон бусад хэлбэртэй боловсруулаагүй эсхүл хагас боловсруулсан алт, алтан зоос, гулдмай зэрэг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглагдах, үнэ цэнээ алдахгүй хадгалагдах алтыг;
- 4.15“Мөнгөжсөн алт” гэж мөнгөний бодлогыг зохицуулах эрх бүхий байгууллага (эсвэл тэдгээрт хяналт тавьдаг бусад этгээд)-ын мэдэлд байдаг санхүүгийн хөрөнгө бөгөөд гадаад валютын нөөцийн бүрэлдэхүүн болгон хадгалдаг алтыг хэлнэ. Мөнгөжсөн алтанд цэвэршүүлээгүй алт (алтны дансанд байршуулсан алтыг оролцуулан) болон гадаадын харьяатаас эдийн засаг руу шилжүүлэхээр тохирсон боловч байршуулаагүй алтыг;
- 4.16“Гүйлгээнд ороогүй мөнгөн тэмдэгт, зоос” гэж гүйлгээнд оруулах зорилгоор Монголбанкнаас гадаад оронд хэвлүүлэн улсын хилээр оруулж байгаа үндэсний мөнгөн тэмдэгтийн /төгрөгийн/ шинэ дэвсгэрт, зоосыг;
- 4.17“Үнэт цаас” гэж Засгийн газар болон бусад эрх бүхий этгээдээс гаргасан өрийн бичиг /бонд/, компанийн бүх төрлийн хувьцаа, компанийн гаргасан, эсхүл гаргахаар санал болгож буй хувьцааг худалдах, худалдан авах эрхийн бичиг /опцион/, хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооноос “Үнэт цаасны зах зээлийн тухай” Монгол улсын хуульд нийцүүлэн гаргасан үнэт цаас гэж тодорхойлсон баримтыг;
- 4.18“Гүйлгээнд ороогүй үнэт цаас” гэж гүйлгээнд оруулах зорилгоор захиалагчаас гадаад оронд хэвлүүлсэн үнэт цаасыг ойлгоно.

## **1.2 Гүйлгээг бүртгэх зарчим**

6. Төлбөрийн тэнцэлд эдийн засгийн харьяат ба эдийн засгийн харьяат бусын хооронд хийгдсэн гүйлгээг бүртгэхдээ орлого ба зарлагын давхар бичилтийн зарчмыг мөрдөнө. Аливаа гүйлгээг кредит бичилтээр орлогын талд эх үүсвэр нэмэгдүүлэх, дебет бичилтээр зарлагын талд эх үүсвэрийг хорогдуулах бичилт хийнэ.
7. Монгол Улсын төлбөрийн тэнцэлд аливаа гүйлгээг америк доллараар бүртгэж, төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлийг сая америк доллараар тайлагнана. Төгрөгийн гүйлгээг америк долларт хөрвүүлэхдээ Монголбанкны тухайн сар, улирал, жилийн дундаж ханшийг хэрэглэнэ.

8. Төлбөрийн тэнцэлд гүйлгээг бүртгэлийн аккруэл суурьт тулгуурлан эдийн засгийн өртөг бий болсон, хөрвүүлсэн, солилцсон, шилжүүлсэн цаг хугацаагаар бүртгэнэ.

### **1.3 Ажил, гүйлгээ, актив, пассивын үлдэгдлийн үнэлгээ**

9. Ажил, гүйлгээг харилцагчдын тохирсон тухайн үеийн үнээр, харин актив, пассивийн үлдэгдлийг тайлан тэнцэл гарах үеийн зах зээлийн үнээр үнэлнэ.
10. Бараа солилцоо, татвар төлөлт, толгой компани болон салбар нэгжийн хооронд хийгдэх ажил, гүйлгээ, менежментийн хувьд нэгдсэн үйлдвэрийн газрын хооронд хийгдэх ажил гүйлгээ, санхүүгийн лизингийн гүйлгээ, эдийн засгийн нэгж хооронд бэлэг, тусламж хэлбэрээр шилжих ажил, гүйлгээ зэргийг зах зээлийн үнээр үнэлэхгүй байж болно. Зах зээлийн үнээр тооцох боломжгүй гүйлгээний хувьд дундаж ханшийг хэрэглэнэ.
11. Төлбөрийн тэнцлийг боловсруулахад ашиглах зорилгоор СИФ нөхцөлийн үнээрх импортын хэмжээг ФОБ /экспортлогч орны хил хүртэлх-ДАФ/ нөхцөл рүү шилжүүлэн тооцоход гаалийн статистикт тусгайлан шаардлагатай тээвэр, даатгалын зардлыг ашиглана.

### **1.4 Тэнцэлд ашиглагдах ангилал**

12. Төлбөрийн тэнцлийг боловсруулахад “Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн ангилал (БҮНА)(ҮСХ-ны дарга, УБЕГ-ын дарга, МШХХТГ-ын даргын 2011 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн 159/784/153 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан), “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ЭЗҮАСА)(Сангийн сайдын 2011 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 103 дугаар тушаалаар батлагдсан), “Эдийн засгийн секторын ангилал”(ҮСХ-ны 2008 оны 4 дүгээр сарын 24-ны өдрийн 01/57 тоот тушаалаар батлагдсан)-ыг хэрэглэнэ.
13. Төлбөрийн тэнцлийн хөрөнгө ба санхүүгийн дансны гүйлгээг эдийн засгийн үндсэн 4 бүлгээр бүлэглэж харуулна. Үүнд:
- Засгийн газар;
  - Төв банк (Монголбанк);
  - Хадгаламжийн байгууллага<sup>1</sup>;
  - Бусад
    - Аж ахуйн нэгж
    - Өрх, төрийн бус байгууллага

### **1.5 Алдаа ба орхигдуулга**

14. Төлбөрийн тэнцлийн бүртгэлд гүйлгээ нь нэмэх, хасах бичилтээр зөрүүгүй тэг байхаар цэвэр дүнгээр илэрхийлэгдэнэ. Бодит амьдрал дээр бүх гүйлгээг бүртгэсний дараа цэвэр дебет эсвэл цэвэр кредитэдүлдэгдэл зайлшгүй гарна. Энэ нь тэнцлийг баланслуулах явцад гарсан алдаа, зөрүү байдаг.
15. Төлбөрийн тэнцлийг боловсруулах явцад гарсан баланслалтын алдаа, зөрүүг залруулга хийн тэнцэлд тусгайлан тэмдэглэнэ. Энэхүү алдаа, зөрүүг баланслалтын буюу статистикийн зөрүү гэдэг. Энэ нь боловсруулалтын явцад бүртгэлийн үзүүлэлтийг давхар эсвэл дутуу тооцоноос гарна. Энэ тохиолдолд тооцооны алдаа, зөрүүг кредит талд тусгасан бол ижил хэмжээгээр дебет талд тусгана.

---

<sup>1</sup>Банкболон хадгаламж, зээлийн хоршоо

16. Тэнцлийн алдаа, зөрүү нь ихэвчлэн санхүүгийн дансны цэвэр зээл/цэвэр зээллэгээс хасагдах урсгал болон хөрөнгийн дансны ижил үзүүлэлт байх бөгөөд ихэнхдээ дараах хандлагатай байна. Тухайлбал:
- Урсгал болон хөрөнгийн дансны кредит гүйлгээний дүн хэтэрхий бага;
  - Урсгал болон хөрөнгийн дансны дебет гүйлгээний дүн хэтэрхий их;
  - Хөрөнгийн дансны хөрөнгийн цэвэр өсөлт хэтэрхий өндөр;
  - Санхүүгийн дансны пассивын цэвэр өсөлтийн дүн хэтэрхий бага байна.
17. Тэнцлийн цэвэр алдаа, зөрүү нь хасах дүнтэй бол дээрх хандлага нь урвуугаар байна.
18. Төлбөрийн тэнцлийн мэдээллийн эх сурвалж нь бүх гүйлгээг бүрэн хамарч чаддаггүй тул давхар бичилтийн аль нэг гүйлгээг орхигдуулсан дүнг алдаа ба орхигдуулга үзүүлэлтэнд тусгана.

## 1.6 Тайлангийн хугацаа

19. Монгол Улсын төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлийг сар, улирал, жилээр гаргана. Төлбөрийн тэнцлийг сар, улирал, жилээр нэгтгэхдээ харьяат ба харьяат бусын хооронд тухайн сар, улирал, жилд хийгдсэн гүйлгээг тайлагнана.
20. Гүйлгээ хийгдсэнийг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

Урсгал данс	– Төлбөр хийгдсэн байдлыг үл харгалзан тухайн бараа бүтээгдэхүүн нэг өмчлөлөөс нөгөө өмчлөлд шилжсэн бол
	– Үйлчилгээ хийгдсэн бол
	– Орлого, зарлагын бүртгэл хийгдсэн бол,
	– Ногдол ашгийн хуваарилалт хийгдсэн бол,
	– Шилжүүлэг хийгдсэн эсвэл авлага, өглөгийг бүртгэсэн бол;
Хөрөнгө ба санхүүгийн данс:	– Биет болон мөнгөн хөрөнгийн эзэмшигчийн өмчлөх эрх бусдад шилжсэн бол,
	– Санхүүгийн хэлцэлд оролцогч хоёр тал өглөг, авлагын бичилт хийсэн бол,
	– Зээлийн ашиглалт, эргэн төлөлт хийгдсэн бол гүйлгээ хийсэн гэж үзнэ.

## 1.7 Төлбөрийн тэнцлийн үзүүлэлт

21. Төлбөрийн тэнцлийн нэгтгэлийг дараах 3 үндсэн дансаар харуулна:
- Урсгал данс
  - Хөрөнгийн данс
  - Санхүүгийн данс
22. Монгол Улсын төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлийг тайлагнахдаа хавсралт 1-д заасан хураангуй болон хавсралт 2-т заасан стандарт хүснэгтийн дагуу боловсруулж, нийтэд тайлагнана.

## 2. Урсгал данс

Урсгал данс нь эдийн засгийн харьяат болон харьяат бусын хоорондох бараа, үйлчилгээний худалдаа, анхдагч болон хоёрдогч орлогын урсгалыг харуулна.

Урсгал данс = Бараа, үйлчилгээний худалдаа + Анхдагч орлого + Хоёрдогч орлого

## 2.1 Бараа болон үйлчилгээний худалдаа

### 2.1.1 Барааны данс

Барааны дансанд эдийн засгийн харьяат болон харьяат бусын хооронд хийсэн барааны өмчлөл шилжсэн экспорт, импортын дүнг бүртгэнэ. Барааны данс нь ерөнхий эд бараа болон бусад бараанаас бүрдэнэ.

#### 1. Ерөнхий эд барааны экспорт, импортод дараах барааны гүйлгээ багтана. Үүнд:

- Гүйлгээнд ороогүй мөнгөн тэмдэгт, зоос, үнэт цаас;
- Цахилгаан эрчим хүч, хий, ус;
- Арилжааны зориулалттай програм хангамж, бичлэг хийгдсэн аудио, видео хальс;
- Боомтод нийлүүлсэн бараа;
- Санхүүгийн лизингийн дагуу өмчлөл нь харьяат болон харьяат бусын хооронд шилжсэн бараа;
- Нууцаар хилээр оруулж ирсэн/гаргасан бараа;
- Бэлэг;
- Өмчлөл шилжсэн мал;
- Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжийн бараа;
- Засгийн газрын худалдааны хэлэлцээр, гадаад тусламжийн хөтөлбөр болон дайны нөхөн төлбөрийн дагуу эдийн засгийн нутаг дэвсгэрт оруулж, түүнээс гаргаж байгаа иргэний болон цэргийн зориулалттай бараа /төлбөр, хандив, зээл, солилцооны бараа хамаарна/;
- Хөрөнгө оруулалтын бараа;
- Цэргийн зориулалттай бараа;
- Арилжааны шинж чанартай зорчигчийн бараа;
- Консигнацийн бараа (улсын хил нэвтрэх үед өмчлөлийн эрх шилжээгүй, арилжих зорилго бүхий бараа, тухайлбал үзэсгэлэн, яармагт тавигдаж буй бараа);
- Толгой компани болон түүний шууд хөрөнгө оруулалтаар бий болсон охин компанийн хооронд шилжүүлж буй бараа;
- Улс хоорондын шуудан илгээмжийн арилжааны шинж чанартай бараа;
- Шилжин суурьшигчдын үнэ бүхий эд хогшил;
- Тодорхой үнэ өртөг бүхий үйлдвэрлэлийн хаягдал, үлдэгдэл /тухайлбал, хаягдал лааз, хүнсний үйлдвэрлэлээс гарсан үлдэгдэл, хаягдал зэрэг/, аюултай хог хаягдал;
- Усан онгоц, агаарын болон бусад тээврийн хэрэгсэл;
- Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын нисэх онгоцонд олгосон түлш, шатахуун, хүнс болон бусад эд зүйл;
- Монгол улсын нутаг дэвсгэрт гадаадын нисэх онгоцноос дотоодын нисэх онгоцонд олгосон түлш, шатахуун, хүнс, бусад эд зүйл болон гадаадын нисэх онгоцноос дотоодын нисэх буудалд буулгасан бараа зэрэг багтана.



## 2. Бусад барааны экспорт, импортод дараах бараа, гүйлгээ багтана. Үүнд:

- Мөнгөжөөгүй алт, энд нөөц актив (мөнгөжсөн алт)-аас бусад бүх төрлийн алтны экспорт, импортын гүйлгээ;
- Барааны өмчлөл шилжсэн боловч худалдан авагчийн нутаг дэвсгэр дээр биетээр ирэлгүй дахин борлуулагдсан бараа.

**Экспорт ФОБ.**Харьяатаас харьяат бусруу улсын хил давуулж нийлүүлсэн барааг экспортод бүртгэх бөгөөд дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Бичилт: кредит: гадаад худалдааны барааны экспортын дүн  
дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гадаад худалдааны барааны статистикийн мэдээ, аж ахуйн нэгжийн тайлан.

### **Импорт ФОБ.**

Харьяат, харьяат бусын хооронд өмчлөл нь шилжиж, улсын хилээр орж ирсэн бараа бүртгэх бөгөөд дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Бичилт: дебет: гадаад худалдааны барааны импортын дүн  
кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гадаад худалдааны барааны статистикийн мэдээнд импортын барааг СИФ нөхцөлөөр бүртгэдэг тул ФОБ нөхцөлд шилжүүлж тооцно (түүвэр судалгааны үндсэн дээр гадаадын бэлтгэн нийлүүлэгчдээс үзүүлсэн бараа тээвэрлэлтийн болон даатгалын үйлчилгээний үнэ, өртгийг барааны үнээс хасч тооцно).

Түүнчлэн харьяат, харьяат бусын хооронд өмчлөл нь шилжсэн хэдий ч улсын хилээр оруулж, гаргаагүй барааг энэ дансанд цэвэр дүнгээр бүртгэнэ.

Мэдээллийн эх үүсвэр:Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гадаад худалдааны барааны статистикийн мэдээ, аж ахуйн нэгжийн тайлан.

Экспорт, импортын гүйцэтгэлд оруулан тооцохгүй бараа:

- Дамжин өнгөрөх бараа;
- Цагаачдын хувийн эд зүйл;
- Гадаад оронд суугаа элчин сайдын яам, консулын газрын өөрийн харьяа улсаас авсан бараа болон Монгол Улсын эзэмшлийн газар нутагт байрлаж буй харьяат бусын элчин сайдын яам, консулын газрын өөрийн орноос авсан бараа;
- Өмчлөлийн өөрчлөлтгүйгээр засварлах, хадгалах гэх мэт зорилгоор түр хугацаар экспортолсон, импортолсон бараа;
- Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйл;
- Мөнгөжсөн алт;
- Гүйлгээнд оруулсан мөнгөн дэвсгэрт, зоос, үнэт цаас /үүнд гадаад валютын зузаатгал орно/;
- Хилийн чанадад 1 жилээс дээшгүй хугацаагаар гаргасан, гаалийн нутаг дэвсгэрт 1 жилээс дээшгүй хугацаагаар оруулсан бараа;

- Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх бараа;
- Захиалгын дагуу хийгдсэн програм хангамж, түүнийг агуулж байгаа диск, эх бичлэг хийгдсэн аудио болон видео хальс; захиалгаар хийгдсэн зураг төсөл;
- Нэг жилээс дээшгүй хугацаагаар түрээслэх бараа;
- устгах бараа;
- Зах зээлийн үнэ цэнэгүй бараа;
- Эдийн засгийн харьяат хооронд хийгдсэн худалдаа;

Барааны экспорт, импортын дүнд оруулж тооцохгүй, тусгайлан бүртгэх бараа:

- гадаад орны нутаг дэвсгэрт газардсан Монголын нисэх онгоцны хэрэгцээнд олгосон түлш, шатахуун, хүнс болон бусад эд зүйл;
- гадаад орны нутаг дэвсгэрт байгаа Монголын нисэх онгоцноос гадаадын нисэх онгоцонд олгосон түлш, шатахуун, хүнс болон бусад эд зүйл;
- Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагын Монгол Улсаас худалдаж авсан бараа;
- давагдашгүй хүчин зүйлийн улмаас гарсан хохирлыг арилгах, барилга, байгууламж барих зэрэг тодорхой зорилгоор гаалийн нутаг дэвсгэрт 1 жилээс дээшгүй хугацаагаар нэвтрүүлсэн машин механизмыг дотоодын хэрэглээнд оруулах эсхүл хилийн чанадад гаргах тохиолдолд;
- улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бараа.

## 2.1.2 Үйлчилгээ

Эндбусдын эзэмшлийн бараа, бүтээгдэхүүнд нэмэлт боловсруулалт хийх үйлчилгээ, засварын үйлчилгээ, тээвэр, аялал жуулчлал, харилцаа холбоо, компьютер мэдээлэл, барилгын ажил, даатгал, санхүү, оюуны өмч ашиглах эрхийн хураамж, бусад бизнес, амралт соёлын болон Засгийн газрын үзүүлсэн үйлчилгээний нийлбэрээс бүрдэнэ. Харьятаас харьяат буст үзүүлсэн үйлчилгээний орлогыг кредит бичилтээр эх үүсвэрийг нэмэгдүүлж, харин харьяатын харьяат буст төлсөн үйлчилгээний зардлыг дебет бичилтээр эх үүсвэрийг хорогдуулж бүртгэнэ.

**2.1.2.1 Бусдын эзэмшлийн бараа бүтээгдэхүүнд нэмэлт боловсруулалт хийх үйлчилгээнд** харьяат нь өөрийн эзэмшлийн бараа бүтээгдэхүүнд харьяат бусаар нэмэлт боловсруулалт хийлгэх эсвэл харьяат бус нь өөрийн эзэмшлийн бараа бүтээгдэхүүнд харьяатаар нэмэлт боловсруулалт хийлгэх үйлчилгээг бүртгэнэ. Тухайлбал, бараа бүтээгдэхүүнийг угсрах, шошголох, савлах, баглаж боох, нэмэлт боловсруулалт хийх зэрэг үйлчилгээ орно. Бараа бүтээгдэхүүний эзэмшил өөрчлөгдөхгүй учраас бараа бүтээгдэхүүний гадаад гүйлгээнд бүртгэгдэхгүй. Харин нэмэлт үйлчилгээг үзүүлэх явцад шаардлагатай барааг эзэмшигчийн оршин буй эдийн засгаас худалдан авсан тохиолдолд бүртгэгдэхгүй. Хэрэв эцсийн бараа бүтээгдэхүүнд нэмэлт үйлчилгээ үзүүлсэн эдийн засгийн нутагт эсвэл гуравдагч улсад худалдан борлуулсан тохиолдолд түүнийг бараа бүтээгдэхүүний экспортод бүртгэнэ.

2.1.2.1.1 Харьят бус нь харьяатаар өөрийн эзэмшлийн бараа бүтээгдэхүүнд нэмэлт боловсруулалт хийсний орлогыг бүртгэхдээ дараах бичилтийг хийнэ.

<u>Бичилт:</u>	кредит:	Нэмэлт боловсруулалт хийсний орлого
	дебит:	санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

2.1.2.1.2 Харьяат нь харьяат бусаар өөрийн эзэмшлийн бараа бүтээгдэхүүнд нэмэлт боловсруулалт хийлгэсний зардлыг бүртгэхдээ дараах бичилтийг хийнэ.

Бичилт: кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

дебит: Нэмэлт боловсруулалт хийлгэсний зардал

Мэдээллийн эх үүсвэр: Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гадаад худалдааны 150 дугаар хэлцлээр хийгдсэн экспорт, импортын барааны мэдээ, нэмэлт тооцоолол, түүвэр судалгаа.

**2.1.2.2 Засвар үйлчилгээнд** харьяат болон харьяат бусын хооронд үзүүлсэн урсгал болон төлөвлөгөөт засварын үйлчилгээг бүртгэнэ. Засвар үйлчилгээ нь засварлагчийн нутаг дэвсгэр дээр явагдаж болно. Усан онгоц, агаарын хөлөг болон бусад тээврийн тоног төхөөрөмжийн засварыг мөн энд бүртгэнэ. Засвар үйлчилгээ үзүүлэх явцад уг үйлчилгээг үзүүлж буй талаас нийлүүлсэн сэлбэг хэрэгсэл нийт засварын төлбөрт бичигдсэн бол тэдгээрийг засвар үйлчилгээнд хамруулна. Харин засварын үйлчилгээнд оруулалгүйгээр тусд нь худалдаж авсан сэлбэг хэрэгсэл бараанд бүртгэгдэнэ. Энэ төрлийн гүйлгээний бичилтийг дараах байдлаар хийнэ.

#### **Засвар үйлчилгээний орлого**

Бичилт: кредит: засвар үйлчилгээний орлого

дебит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

#### **Засвар үйлчилгээний зардал**

Бичилт: кредит: засвар үйлчилгээний зардал

дебит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: МИАТ Хувьцаат компани, Улаанбаатар төмөр зам Хувь нийлүүлсэн нийгэмлэгийн тайлан, гадаад гүйлгээний тайлан.

Тээврийн хэрэгслийг цэвэрлэх үйлчилгээ нь тээврийн үйлчилгээнд, барилгын засварын үйлчилгээ нь барилгын ажил үйлчилгээнд, компьютер засвар нь харилцаа холбоо, засварын үйлчилгээнд хамрагдана.

**2.1.2.3 Тээврийн үйлчилгээнд** харьяат ба харьяат бусын хооронд хийгдсэн хүн болон эд зүйлийг нэг байршлаас нөгөө байршилд тээвэрлэх явц, түүнтэй холбоотойгоор гарсан туслах болон нэмэлт үйлчилгээ, түүнчлэн тээврийн хэрэгслийг хөдөлгөгч багийн хамт түрээслэх үйлчилгээ, шуудан илгээмж, буухиа шуудангийн үйлчилгээгэнд бүртгэнэ.

#### **А. Тээврийн үйлчилгээний төрлүүд:**

2.1.2.3.1 Далайн тээвэрлэлтэд далайгаар олон улсын ачаа, зорчигч тээвэрлэсэн болон бусад туслах үйлчилгээг бүртгэнэ.

- 2.1.2.3.2 Агаарын тээвэрлэлтэд агаарын тээврийн хэрэгслээр олон улсын ачаа, зорчигч тээвэрлэсэн болон бусад туслах үйлчилгээг бүртгэнэ.
- 2.1.2.3.3 Илгээмж, буухиа шуудангийн үйлчилгээнд захиа, сонин хэвлэл, шуудан илгээмжийн тээвэрлэлт болон шуудангийн хайрцагны үйлчилгээг бүртгэнэ.
- 2.1.2.3.4 Сансрын тээвэрлэлтэд харилцаа холбооны компаниуд хиймэл дагуул хөөргөх, бусад сансрын тээврийн хэрэгсэлтэй холбоотой хийж гүйцэтгэсэн бусад үйл ажиллагаа, эрдэм шинжилгээ, судалгааны зорилгоор зорчигч болон бараа сансарт явуулахыг бүргэнэ. Мөн өөрийн харьяатын сансарт нисэх зардлыг тухайн улсаас төлж байвал бүртгэнэ.
- 2.1.2.3.5 Төмөр замын тээвэрлэлтэд галт тэргээр олон улсын ачаа, зорчигч тээвэрлэсэн болон бусад туслах үйлчилгээг бүртгэнэ.
- 2.1.2.3.6 Авто замын тээвэрлэлтэд авто замаар олон улсынаачаа, зорчигч тээвэрлэсэн болон бусад туслах үйлчилгээг бүртгэнэ.
- 2.1.2.3.7 Усан замын тээвэрлэлтэд тухайн эдийн засгийн нутаг дэвсгэрт орших эсвэл бусад улсуудтай хамтран эзэмшдэг гол, ус суваг, нуураар дамжуулан хийсэн ачаа, зорчигч тээвэрлэлт болон бусад туслах үйлчилгээг бүртгэнэ.
- 2.1.2.3.8 Дамжуулах хоолойны тээвэрлэлтэд нефть, ус, хийн тээвэрлэлтийг бүртгэнэ. Харин тээвэрлэлтийн станцаас эцсийн хэрэглэгчрүү түгээх (бусад бизнесийн үйлчилгээ) болон тээвэрлэгдэж буй бараа бүтээгдэхүүний өртгийг (бараа бүтээгдэхүүн) дамжуулах хоолойны тээвэрлэлтэд бүртгэхгүй.
- 2.1.2.3.9 Цахилгаан дамжуулах үйлчилгээнд цахилгаан эрчим хүчийг өндөр хүчдэлээр харилцан холбогдсон шугамаар дамжуулах тээвэрлэлтийг бүртгэнэ.
- 2.1.2.3.10 Бусад тээвэрлэлтийн үйлчилгээнд дээрх ангилалд багтахгүй тээврийн холбогдолтой бусад үйлчилгээг бүртгэнэ.

## **Б. Ангилал**

2.1.2.3.3, 2.1.2.3.8, 2.1.2.3.9-оос бусад тээврийн үйлчилгээг дотор нь зорчигч, ачаа болон бусад тээвэрлэлт гэж ангилна.

### **Б.1 Зорчигч тээвэрлэлт**

Зорчигч тээврийн үйлчилгээнд олон улс дахь харьяат бусын тээврийн хэрэгслээр харьяат зорчигч үйлчлүүлсэн (дебет) эсвэл харьяатын тээврийн хэрэгслээр харьяат бус зорчигч үйлчлүүлсэн (кредит) бол бүртгэнэ. Зорчигч тээврийн үйлчилгээнд зорчигчийн тийзний үнэ, холбогдох татвар хураамж, илүүдэл ачаа тээшний төлбөр болон бусад хувийн хэрэглээнд зориулан тээврийн хэрэгслээр зорчих хугацаанд худалдан авсан бусад эд зүйлс орно. Мөн харьяат нь харьяат бусаас тээврийн хэрэгслийг жолоодох багийн хамт түрээслэвэл энд бүртгэнэ.

#### **Зорчигч тээвэрлэлтийн орлого**

**Бичилт:** кредит: зорчигч тээврийн орлого  
 дебит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

#### **Зорчигч тээвэрлэлтийн зардал**

Бичилт: кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

дебит: зорчигч тээврийн зардал

Мэдээллийн эх үүсвэр:Гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн тайлан мэдээ,түүвэр судалгаа.

Харьяат бусын эдийн засгийн нутаг дэвсгэр дээр тээвэрлэсэн зорчигч тээврийн үйлчилгээ мөн энд хамаарна. Түүнчлэн санхүүгийн түрээсийн үйлчилгээ нь зорчигч тээврийн үйлчилгээнд хамаарахгүй.

## **Б.2 Ачаа тээвэрлэлт**

Ачаа тээвэрлэлтийн үйлчилгээнд олон улсад харьяат ба харьяат бусын хооронд хийгдсэн экспорт, импортын барааны тээвэрлэлтийг бүртгэнэ. Экспортлогч өөрийн эдийн засгийн нутаг дэвсгэрийн хилийн зурвас хүртэл төлсөн ачаа тээврийн зардал нь экспортлогчоор төлөгдсөн гэж бүртгэгдэнэ. Харин экспортлогчийн эдийн засгийн нутаг дэвсгэрийн хилээс гадна төлөгдсөн тээврийн зардал импортлогчоор төлөгдсөн гэж бүртгэгдэнэ. Тиймээс экспорт, импорттой холбоотой ачаа тээврийн зардлыг бүртгэх нь ачаа тээврийн үйлчилгээ үзүүлж буй аж ахуйн нэгжийн эдийн засгийн харьяаллаас шалтгаална.

Харьяат ачаа тээврийн компани нь эдийн засгийн нутаг дэвсгэрийн хилээс гадна ачаа тээврийн үйлчилгээ үзүүлсэн бол ачаа тээврийн үйлчилгээний экспорт, харин харьяат бусын ачаа тээврийн компани экспортлогчийн эдийн засгийн нутаг дэвсгэр дээр ачаа тээврийн үйлчилгээ үзүүлсэн бол тээврийн үйлчилгээний импорт гэж бүртгэнэ. Түүнчлэн бусад улсын эдийн засгийн нутаг дэвсгэр дээгүүр дамжин тээвэрлэсэн тээвэрлэлт, гуравдагч орнуудын хоорондох ачаа тээвэрлэлт болон цагаачдын хувийн эд зүйлийн ачаа тээвэрлэлтийг бүртгэнэ.

### **Ачаа тээврийн орлого**

Бичилт: кредит: ачаа тээврийн орлого

дебит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр:МИАТ Хувьцаат компани, Улаанбаатар төмөр замын болон бусад тээврийн байгууллагын ачаа тээвэрлэлтийн мэдээ, Гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн тусгайлсан судалгаа.

### **Ачаа тээврийн зардал**

Бичилт: дебит: ачаа тээврийн зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр:МИАТ Хувьцаат компани, Улаанбаатар төмөр зам Хувь нийлүүлсэн нийгэмлэгийн мэдээ, бусад тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжийн ачаа тээвэрлэлтийн мэдээ, гадаад гүйлгээний тайлан, түүвэр судалгаа.

### Б.3 Бусад тээвэрлэлт

Бусад тээвэрлэлтийн үйлчилгээнд тээвэрлэлттэй холбоотой бусад туслах үйл ажиллагаа, тухайлбал, усан онгоцны зогсоол, нисэх буудал, зогсоолын үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээ, ачаа тээш хадгалах, баглах, чирэх, баримт бичиг бүрдүүлэх зэрэг үйлчилгээ энд багтана. Үйлчилгээний орлого, зардлыг дараах бичилтийг хийнэ.

#### Тээвэрлэлттэй холбоотой бусад үйлчилгээний орлого

Бичилт: кредит: тээвэрлэлттэй холбоотой бусад үйлчилгээний орлого

дебит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: МИАТ Хувьцаат компани, Улаанбаатар төмөр зам Хувь нийлүүлсэн нийгэмлэг, Иргэний нисэх, нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалт, удирдлагын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ, бусад тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжийнтээвэрлэлтийн мэдээ, гадаад гүйлгээний тайлан, түүвэр судалгаа.

#### Тээвэрлэлттэй холбоотой бусад үйлчилгээний зардал

Бичилт: дебит: тээвэрлэлттэй холбоотой бусад үйлчилгээний зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: МИАТ Хувьцаат компани, Улаанбаатар төмөр зам Хувь нийлүүлсэн нийгэмлэг, Иргэний нисэх, нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалт, удирдлагын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээ, бусад тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжийнтээвэрлэлтийн мэдээ, гадаад гүйлгээний тайлан, түүвэр судалгаа.

Ачаа тээшийг осол, гамшгаас аврах, тээврийн хэрэгслийг усан болон агаарын боомтод цэвэрлэх үйлчилгээ, тээврийн даатгалын үйлчилгээ, харьяат бусын боомтод нийлүүлсэн бараа, тээврийн хэрэгслийн тоног төхөөрөмжийн засварыг энэхүү ангилалд тусгахгүй.

Шуудан холбооны системтэй холбогдсон засаг захиргааны үйлчилгээ, жуулчдад үзүүлэх шуудангийн үйлчилгээ энд хамаарахгүй.

**2.1.2.4 Аялал жуулчлалын үйлчилгээнд харьяат нь өөрийн эдийн засгийн нутаг дэвсгэрээс гадна байх хугацаанд харьяат бусаас хувийн хэрэгцээнд болон бэлгэнд худалдан авсан бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг бүртгэнэ.**

**2.1.2.4.1 Албан томилолтод** засгийн газрын болон олон улсын байгууллага, бизнес эрхлэгч байгууллагын ажилтан олон улсын хурал, зөвлөгөөн, уулзалт, туршлага судлах зэргээр гадаад оронд албан томилолтоор ажиллахтай холбоотой үйл ажиллагааг бүртгэнэ. Албан томилолтын үед байгууллагынхаа нэрийн өмнөөс худалдан авсан бараа үйлчилгээг албан томилолтод оруулахгүй. Жишээ нь: засгийн газрын болон олон улсын байгууллага, бизнес эрхлэгч байгууллагын ажилтан нь арилжааны гэрээ хэлэлцээр зэргийг албан байгууллагын

өмнөөс байгуулснаас үүдэлтэй мөнгөн гүйлгээг албан томилолтод оруулахгүй. Хэрэв улирлын шинж чанартай, хилийн болон бусад харьяат бус ажилчид харьяатын эдийн засгийн нутаг дэвсгэр дээрээс өөрийн хэрэгцээнд зориулан бараа үйлчилгээ худалдан авбал тусад нь “хилийн, улирлын, богино хугацааны ажилчдын худалдан авсан бараа үйлчилгээ”-нд бүртгэнэ.

#### **Албан томилолтын орлого**

Бичилт: кредит: албан томилолтын зардал

дебит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр:Түүвэр судалгаа, гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн тайлан.

#### **Албан томилолтын зардал**

Бичилт: дебит: албан томилолтын зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн (Цэвэр нөөцийн нийт актив, бусад актив бүлэгт бусад гүйлгээний хамт шууд тавигдах тул төсвийн байгууллагын зардлын кредит бичилтийг хийхгүй)

Мэдээллийн эх үүсвэр:Түүвэр судалгаа, гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн тайлан.

2.1.2.4.2 **Хувийн аялалд** албан томилолтоос бусад амралт зугаалгын үйл ажиллагаа, тухайлбал, гадаад оронд аялах, урлаг, спорт, уралдаан, тэмцээнд оролцох, найз нөхөд, ах дүү, хамаатан садныдаа зочлох, мөргөл хийх, шашны зан үйлийн ажиллагаанд оролцох болон сургалт, эрүүл мэндийн зорилгоор харьяат бусаас худалдан авсан бараа үйлчилгээг бүртгэнэ.

2.1.2.4.2.1 **Эмчилгээний үйлчилгээнд** харьяат нь эдийн засгийн нутаг дэвсгэрээс гадна эмчилгээ хийлгэх, тэнд байрлах хугацаанд зочид буудал, хоол хүнс, унаанд зарцуулсан зардал болон бусад зардлыг бүртгэнэ.

#### **Эмчилгээний орлого**

Бичилт: кредит: гадаадын иргэдийн эмчилгээний төлбөр

дебит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гадаадын иргэдийн эмчилгээний төлбөрийн судалгаа.

#### **Эмчилгээний зардал**

Бичилт: дебит: Монгол иргэдийн гадаадад эмчлүүлсэн эмчилгээний зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба

харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Гадаадад эмчлүүлэгч Монгол улсын иргэдийн эмчилгээний зардлын түүвэр судалгаа, гадаад гүйлгээний тайлан.

2.1.2.4.2.2 **Сургалтын үйлчилгээнд** харьяат нь гадаад оронд суралцах зорилгоор сургалтын төлбөр, байр хоол, унааны зардал болон бусад зардалд төлсөн төлбөрийг бүртгэнэ.

#### **Сургалтын орлого**

Бичилт: кредит: гадаадын оюутнуудын сургалтын төлбөр

дебит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

#### **Сургалтын зардал**

Бичилт: дебит: гадаадад суралцагчдын сургалтын төлбөр

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Сургалтын төрийн сангийн мэдээ, гадаад орнуудад Сургалтын төрийн сангаас бусад хөрөнгөөр суралцагч монгол оюутнуудын түүвэр судалгаа, гадаад гүйлгээний тайлан.

2.1.2.4.2.3 **Бусад аялалд** эрүүл мэндийн болон сургалтын зорилгоос бусад аялал, жуулчлал, найз нөхөд, хамаатан садныдаа зочлох болон мөргөл хийх, шашны зан үйлийн ажиллагаанд оролцох зэрэг амралт зугаалгын үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг бүртгэнэ.

#### **Жуулчлалын орлого**

Бичилт: кредит: жуулчлалын орлого

дебит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Улсын хил хамгаалалтын талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх, хил хамгаалалтыг зохион байгуулах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Монгол Улсын хилээр орсон/гарсан гадаадын иргэдийн мэдээ, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа, Монгол Улсад ирж буй гадаадын жуулчдын түүвэр судалгаа.

#### **Жуулчлалын зардал**

Бичилт: дебит: жуулчлалын зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн



Мэдээллийн эх үүсвэр: Улсын хил хамгаалалтын талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх, хил хамгаалалтыг зохион байгуулахасуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Монгол Улсын хилээр орсон/гарсан гадаадын иргэдийн мэдээ, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа, Монгол Улсад ирж буй гадаадын жуулчдын түүвэр судалгаа.

Үйлчилгээний гадаад худалдааны статистикийн аргачлалд аялал жуулчлалыг дотор нь худалдан авсан бараа, орон нутгийн тээврийн хэрэгслээр үйлчлүүлсэн зардал, байрны зардал, хоол хүнстэй холбоотой зардал болон бусад зардал гэж ангилан хуваахыг зөвлөмж болгодог.

**2.1.2.5 Барилгын үйлчилгээнд** аж ахуйн нэгж, байгууллагын богино хугацаанд (нэг жил хүртэлх) хийж гүйцэтгэсэн байшин барилга барих, төслийг удирдах, зам гүүр угсрах, засварлах зэрэг үйлчилгээг бүртгэнэ. Мөн барилга байгууламж барихтай холбоотойгоор тоног төхөөрөмж байрлуулах суурилуулах, талбай бэлтгэх, сантехник, гагнуур хийх болон бусад гүйцэтгэсэн ажил үйлчилгээг энд бүртгэнэ. Барилгын үйлчилгээнд тухайн барилга байгууламжийг барихтай холбоотойгоор импортолсон бараа болон үйлчилгээний зардлыг мөн хамруулна. Элчин сайдын яаманд хийж гүйцэтгэсэн барилгын үйлчилгээ болон нэг жилээс дээш үйл ажиллагаа явуулж буй гадаад орны аж ахуйн нэгж салбар үйл ажиллагаа явуулж буй тохиолдолд барилгын үйлчилгээнд хамаарахгүй.

2.1.2.5.1 Эдийн засгийн нутаг дэвсгэр дээр харьяат бус барилгын компанийн үзүүлсэн барилгын үйлчилгээ болон барилга барихтай холбоотой олж эзэмшсэн бараа, үйлчилгээ,

2.1.2.5.2 Эдийн засгийн нутаг дэвсгэрээс гадна харьяат барилгын компани харьяат буст үзүүлсэн барилгын үйлчилгээ болон барилга барихтай холбоотой олж эзэмшсэн бараа, үйлчилгээ.

#### **Барилгын ажил, үйлчилгээний орлого**

Бичилт: кредит: барилгын ажил, үйлчилгээний орлого  
дебит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

#### **Барилгын ажил үйлчилгээний зардал**

Бичилт: дебит: барилгын ажил, үйлчилгээний зардал  
кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, түүвэр судалгаа.

**2.1.2.6 Даатгал, тэтгэвэрийн үйлчилгээнд** харьяат болон харьяат бусын хоорондох даатгалын болон тэтгэвэрийн үйлчилгээг бүртгэнэ.

2.1.2.6.1 Шууд даатгалын үйлчилгээнд амь насны даатгал, ачаа тээвэрлэлтийн даатгал болон бусад шууд даатгалыг бүртгэнэ. Экспорт, импортын барааны ачаа тээврийн даатгалын үйлчилгээг ФОБ нөхцөлийн үнээр үнэлнэ. Үүнтэй уялдан даатгалын үйлчилгээний зардлын тооцоонд импортын СИФ нөхцөлийн үнийг ФОБ нөхцөлийн үнэд шилжүүлэн тооцож тусгана.

- 2.1.2.6.2 Давхар даатгал нь хил дамнан харьяат болон харьяат бус даатгалын компаниудын хооронд өөрт үүссэн эрсдэлийг шилжүүлэх зорилгоор давхар даатгаж буй үйлчилгээ юм.
- 2.1.2.6.3 Бусад холбогдох үйлчилгээнд даатгал болон тэтгэвэрийн үйлчилгээ үзүүлэхэд шууд холбоотойгоор гарсан үйлчилгээний шимтгэл, зөвлөх, үнэлэх, нөхөн олгох болон хянах үйлчилгээний гүйлгээг бүртгэнэ.
- 2.1.2.6.4 Тэтгэвэрийн үйлчилгээнд тодорхой нэг аж ахуйн нэгж, байгууллагад ажилладаг эсвэл хувиараа хөдөлмөр эрхэлдэгхарьяат нь харьяат бус тэтгэвэрийн байгууллага болон санд тодорхой давтамжтайгаар мөнгө хуримтлуулж, түүнийгээ тэтгэвэрт гарах үед орлогын эх үүсвэр болгон авч буй үйлчилгээг хамааруулна.

#### **Даатгал, тэтгэврийн үйлчилгээний орлого**

Бичилт: кредит: Даатгал, тэтгэврийн үйлчилгээний орлого  
дебит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр:Гадаад гүйлгээний тайлан,Засгийн газрын санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын даатгалын үйлчилгээний орлогын мэдээ, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ.

#### **Даатгал, тэтгэврийн үйлчилгээний зардал**

Бичилт: дебит: Даатгал, тэтгэврийн үйлчилгээний зардал  
кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр:Гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа.

**2.1.2.7 Санхүүгийн үйлчилгээнд** харьяат болон харьяат бусын хооронд хийгдсэн даатгал, тэтгэврийн сангаас бусад төрлийн санхүүгийн зуучлал (аккредитивын шимтгэл, санхүүгийн лизингийн шимтгэл, валют хөрвүүлсний шимтгэл гэх мэт), туслах чанарын ажил, үйлчилгээний (санхүүгийн брокерийн хөлс, активын удирдлагын үйлчилгээний хөлс, диллерүүдийн хөлс гэх мэт) орлого, зардлыг бүртгэнэ. Өрийн бичиг гаргахтай холбоотой үйлчилгээ, санхүүгийн зуучлал, зөвлөх, удирдах болон хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээг санхүүгийнүйлчилгээндбүртгэнэ.Санхүүгийн үйлчилгээнд харилцах хадгаламж, зээлд төлсөн хүүгийн орлого, зарлага, ногдол ашиг, санхүүгийн бус зөвлөх үйлчилгээ, үнэт цаах худалдах, худалдан авснаас үүдэлтэй ашиг алдагдал зэргийг бүртгэхгүй. Санхүүгийн үйлчилгээнд бүртгэх дүн нь тодорхой бол тэр дүнгээр бүртгэнэ. Харин хадгаламж, харилцах, зээлийн үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд санхүүгийн үйлчилгээний хөлсийг тухайн үйлчилгээний хүү болон эх үүсвэрийн өртөгийн зөрүүгээр тодорхойлно. Эх үүсвэрийн өртгийг дотоодын валютаарх харилцах, хадгаламж, зээлд банк хоорондын зээлийн хүү эсвэл Төв банкны зээлийн хүүгээр тооцох бөгөөд харин бусад валютын хувьд өөр хүүг ашиглана.

#### **Санхүүгийн үйлчилгээний орлого**

Бичилт: кредит: санхүүгийн үйлчилгээний орлого  
дебит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

#### **Санхүүгийн үйлчилгээний зардал**

Бичилт: дебит: санхүүгийн үйлчилгээний зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр:Гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн тайлан, түүвэр судалгаа, нэмэлт тооцоолол.

**2.1.2.8 Харилцаа холбоо, компьютер, мэдээллийн үйлчилгээг** харьяат болон харьяат бусын хооронд хийсэн харилцаа холбооны үйлчилгээ, компьютер, мэдээллийн үйлчилгээ гэж ангилна.

2.1.2.8.1 Харилцаа холбооны үйлчилгээнд харьяат болон харьяат бусын хооронд харилцаа холбоо, шугам кабелийн хэрэгслээр дамжин хийж байгаа дараах үйлчилгээг хамруулан авч үзнэ. Үүнд авиа, зураг, тоон мэдээ дамжуулах, холбооны үйлчилгээ, телефон, телекс, телеграф, радио, телевизийн кабелиар цацагдаж буй өргөн нэвтрүүлэг, сансрын холбоо, электрон шуудан, интернетийн үйлчилгээ, факсын үйлчилгээ зэрэг телекоммуникацийн үйлчилгээ, бүх төрлийн мэдээллийн сүлжээ (Ройтерс, СВИФТ гэх мэт), хиймэл дагуулын ашиглалт (кабелийн телевизийн суваг гэх мэт) зэрэг үйлчилгээг бүртгэнэ.

#### **Харилцаа холбооны үйлчилгээний орлого**

Бичилт: кредит: харилцаа холбооны үйлчилгээний орлого

дебит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

#### **Харилцаа холбооны үйлчилгээний зардал**

Бичилт: дебит: харилцаа холбооны үйлчилгээний зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр:Гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн судалгаа болон Төвбанк, банкуудын СВИФТ болон Ройтерсийн үйлчилгээний зардлын мэдээ.

2.1.2.8.2 Компьютер, мэдээллийн үйлчилгээнд харьяат болон харьяат бусын хооронд үзүүлсэн программ хангамж, мэдээлэл, компьютер, түүнтэй холбоотой тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг бүртгэнэ.

2.1.2.8.2.1 Програм хангамжийн үйлчилгээнд тухайн програмыг ашиглах эрх (лиценз), түүнчлэн програмыг тодорхой хэсэг хэрэглэгчдийн захиалгаар зохион бүтээх, олон нийтэд зориулан хэсэг хугацаанд төлбөр төлж ашиглах, эзэмших програмын худалдан авалтыг бүртгэнэ. Хэрэв тодорхой нэг програм хангамжийг байнгын эзэмших эрхийг зөвхөн нэг этгээдэд худалдах эсвэл худалдан авсан тохиолдолд үүнийг програм хангамжид бус ерөнхий эд бараанд бүртгэнэ.

2.1.2.8.2.2 Мэдээллийн үйлчилгээнд мэдээллийн агентлагийн үйлчилгээ (сонин, тогтмол хэвлэлийн захиалга) болон бусад мэдээллийн үйлчилгээ болон тоо мэдээллийн

хадгалалт, цахим хайлтын үйлчилгээ, цахим номын сан, архивын үйлчилгээг бүртгэнэ.

#### **Компьютер, мэдээллийн үйлчилгээний орлого**

Бичилт: кредит: компьютер, мэдээллийн үйлчилгээний орлого

дебит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

#### **Компьютер, мэдээллийн үйлчилгээний зардал**

Бичилт: дебит: компьютер, мэдээллийн үйлчилгээний зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн тайлан.

**2.1.2.9 Оюуны өмч ашиглах эрхийн хураамжид** харьяат болон харьяат бусын хооронд биет бус өмч хөрөнгийн эзэмших эрх (худалдааны тэмдэгт, патент, франчайзийн эрхийн хураамж) шилжих, мөн оюуны өмчийг олшруулах, түгээх эрхийг (зохиогчийн эрх, програм технологийг ашиглах, кино театрт кино үзүүлэх эрх, концерт, тэмцээн уралдааныг мэдээллийн хэрэгслээр үзүүлэх эрх) худалдах, худалдан авах, тэдгээртэй холбоотой бусад үйлчилгээг бүртгэнэ.

#### **Оюуны өмч ашиглах эрхийн хураамжийн үйлчилгээний орлого**

Бичилт: кредит: оюуны өмч ашиглах эрхийн хураамжийн үйлчилгээний орлого

дебит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Оюуны өмчийн газрын оюуны өмчийн хураамж болон эрх худалдсан орлогын мэдээ, гадаад гүйлгээний тайлан, түүвэр судалгаа.

#### **Оюуны өмч ашиглах эрхийн хураамжийн үйлчилгээний зардал**

Бичилт: дебит: оюуны өмч ашиглах эрхийн хураамжийн үйлчилгээний зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн тайлан, түүвэр судалгаа.

**2.1.2.10 Бизнесийн бусад үйлчилгээнд** харьяат болон харьяат бусын хооронд хийсэн өмнө дурьдагдсанаас бусад үйлчилгээг бүртгэнэ.

**2.1.2.10.1 Судалгаа шинжилгээ, хөгжлийн үйлчилгээнд** харьяат болон харьяат бусын хоорондох суурь судалгаа, практик судалгаа, шинэ бүтээгдэхүүн боловсруулалт болон физик, нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухаантай холбоотой судалгаа шинжилгээний үйлчилгээг бүртгэнэ. Техникийн судалгаа шинжилгээ, зөвлөх үйлчилгээ энд хамаарахгүй. Судалгаа болон боловсруулалтын үйлчилгээг дотор нь мэдлэг нэмж бий болгох зорилгоор системтэйгээр авч хэрэгжүүлсэн болон бусад үйлчилгээ гэж ангилна.

- 2.1.2.10.2 **Мэргэжлийн болон удирдлагын зөвлөх үйлчилгээнд** харьяат болон харьяат бусын хоорондох хууль зүй, нягтлан бодох бүртгэл, удирдлагын зөвлөх үйлчилгээ болон сурталчилгаа, зах зээлийн судалгаа, нийтийн саналын судалгааны үйлчилгээг бүртгэнэ.
- 2.1.2.10.2.1 Хууль зүйн үйлчилгээнд хууль зүйн зөвлөгөө, хуулийн төлөөллийн үйлчилгээ болон хууль зүйн баримт бичиг боловсруулах үйлчилгээг бүртгэнэ.
- 2.1.2.10.2.2 Нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээнд нягтлан бодох бүртгэл, татварын зөвлөгөө болон аудитын үйлчилгээг бүртгэнэ.
- 2.1.2.10.2.3 Бизнесийн, удирдлагын зөвлөх үйлчилгээнд байгууллагын бизнесийн стратеги, үйл ажиллагаа бүтэц, хяналт зэрэгт зөвлөгөө, зааварчилгаа өгөх болон бусад туслалцаа үзүүлэх үйлчилгээг бүртгэнэ. Эдгээр үйлчилгээнд удирдлагын аудит, зах зээлийн удирдлага, хүний нөөц, үйлдвэрлэлийн болон төслийн удирдлага, үйлчлүүлэгчийн нэр хүнд, олон нийттэй харилцах харилцааг сайжруулах зэрэг үйлчилгээг хамруулна.
- 2.1.2.10.2.4 Сурталчилгаа, зах зээлийн судалгаа болон нийтийн саналын судалгааны үйлчилгээнд сурталчилгаа захиалгаар хийх, харилцаа холбооны хэрэгслээр явуулах, гадаад бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, зах зээлийн судалгааны үйлчилгээ, теле маркетинг болон олон нийтийн саналын судалгаа үзүүлсэн үйлчилгээг бүртгэнэ.
- 2.1.2.10.3 **Техникийн болон худалдаатай холбоотой бусад үйлчилгээнд** харьяат болон харьяат бусын хоорондох дараахь үйлчилгээг бүртгэнэ. Үүнд:
- 2.1.2.10.3.1 Архитектор, инженер, шинжлэх ухаан болон технологийн үйлчилгээнд харьяат болон харьяат бусын хоорондох барилга байгууламжийн загвар, зураг төсөл боловсруулах, машин техникийн загвар зохиох, бүтэц төлөвлөх, үйл явц боловсруулах, судалгаа, бүтээгдэхүүнийг турших, шалгах болон техникийн оношлогооны үйлчилгээг бүртгэнэ.
- 2.1.2.10.3.2 Байгалийн хог хаягдал, бохирдлын цэвэрлэгээний үйлчилгээ, хөдөө аж ахуй, ан агнуур, ойжуулалтын үйлчилгээ болон уул уурхай, тос, хий олборлолттой холбоотой үйлчилгээнд:
- 2.1.2.10.3.2.1 Хог хаягдал, бохирдлын цэвэрлэгээний үйлчилгээнд байгаль орчны нөхөн сэргээлт, бохирдсон газрын хөрсний цэвэрлэгээ болон орчин тойрны бохирдол хорыг цэвэрлэх үйлчилгээг бүртгэнэ.
- 2.1.2.10.3.2.2 Хөдөө аж ахуй, ан агнуур, ойжуулалтын үйлчилгээнд хөдөө аж ахуйн техник тоног төхөөрөмжийг хөдөлгөх багийн хамт авч ажиллуулах, талбай дээрх хортон шавьжийн устгал, мал аж ахуйн үйлчилгээ болон ан агнууртай холбоотой үйлчилгээг бүртгэнэ.
- 2.1.2.10.3.2.3 Уул уурхай, тос, хий олборлолттой холбоотой үйлчилгээнд газрын өрөмдөлт, олборлолт, геологийн судалгаа шинжилгээ болон бусад холбогдох үйлчилгээг бүртгэнэ.

- 2.1.2.10.3.3 Үйл ажиллагааны түрээсийн үйлчилгээнд тээврийн хэрэгслийг жолоочгүйгээр нь (санхүүгийн лизингээс бусад) түрээслэх, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж болон бусад үйл ажиллагааны түрээсийг бүртгэнэ.
- 2.1.2.10.3.4 Худалдаатай холбоотой үйлчилгээнд барааг худалдаалах болон худалдааны үйл ажиллагаатай холбоотой бусад үйлчилгээ багтана. Бараа, үйлчилгээний гүйлгээний хураамжаас барааг зуучлах үйлчилгээ бүрдэнэ. Худалдаачин, худалдааны брокер, наймаачин, комиссын агент зэргээр хийгддэг харьяат болон харьяат бусын хоорондын худалдааны гүйлгээ байна.
- 2.1.2.10.3.5 Бусад үйлчилгээнд ажилтан байршуулах, хамгаалал болон мөрдлөгийн үйлчилгээ, түүнчлэн орчуулга, фото зургийн үйлчилгээ, барилга, байшин, байгууламжийн цэвэрлэгээ зэрэг багтана. Харьяат бусын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд үзүүлж байгаа орон нутгийн үйлчилгээ, орон сууцны хангамж, үйлчилгээ зэрэг нь барилгын үйлчилгээний төлбөрт орж тооцогдоно.

#### **Бизнесийн бусад үйлчилгээний орлого**

Бичилт: кредит: бизнесийн бусад үйлчилгээний орлого

дебит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

#### **Бизнесийн бусад үйлчилгээний зардал**

Бичилт: дебит: бизнесийн бусад үйлчилгээний зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Гадаад гүйлгээний тайлан, түүвэр судалгаа, аж ахуйн нэгж, байгууллагын тайлан.

#### **2.1.2.11 Хувийн соёл, урлаг, чөлөөт цагийн үйлчилгээнд харьяат болон харьяат бусын хооронд хийгдсэн дүрс, дуу бичлэг тэдгээртэй холбогдох үйлчилгээ болон бусад хувийн соёл урлагийн, чөлөөт цагийн үйлчилгээг бүртгэнэ.**

2.1.2.11.1 Дуу, дүрс харах, түүнтэй холбоотой үйлчилгээнд кино зураг (кино болон видео хуурцаг)-ийн үйлдвэрлэл, радио, телевизийн хөтөлбөрийн төлбөрийн үйлчилгээ хамаарах бөгөөд харьяат жүжигчин, удирдаач, продюсерийн (харьяат бусын эдийн засгийн нутаг дэвсгэрт хийсэн) гадаад оронд явуулсан үйлдвэрлэл, үйлчилгээний хураамж, түрээсийн төлбөр эсвэл хүлээн авсан нэхэмжлэл, тусгай бүсэд үзүүлэх бүтээлийг нийтэд гаргах эрх зэргийг мөн багтаан авч үзнэ.

2.1.2.11.2 Бусад соёл, урлаг чөлөөт цагийн үйлчилгээнд театр, хөгжмийн бүтээл, спортын арга хэмжээ, цирк зэрэгт оролцож байгаа жүжигчин,

продюсер зэргийн хураамж болон телевиз, радиогийн бүтээлийг нийтэд түгээх эрхийн төлбөр, хураамж мөн багтана.

### **Хувийн соёл, урлаг, чөлөөт цагийн үйлчилгээний орлого**

Бичилт: кредит: хувийн соёл, урлаг, чөлөөт цагийн үйлчилгээний орлого

дебит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

### **Хувийн соёл, урлаг, чөлөөт цагийн үйлчилгээний зардал**

Бичилт: дебит: хувийн соёл, урлаг, чөлөөт цагийн үйлчилгээний зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Гадаад гүйлгээний тайлан, түүвэр судалгаа.

**2.1.2.12 Засгийн газрын бараа, үйлчилгээнд** а) элчин сайдын яам, цэргийн баазад нийлүүлсэн бараа, үйлчилгээ; б) дипломат, консулын газрын ажилчид, харьяат бус цэргийн албан хаагчид болон тэдний гэр бүлийнхний харьяатын нутаг дэвсгэр дээрээс авсан бараа, үйлчилгээ; в) үйлчилгээний бусад ангилалд ороогүй засгийн газрын бусад үйлчилгээг бүртгэнэ. Олон улсын байгууллагын төлөөлгчийн газар нь оршин буй нутаг дэвсгэрийн харьяатад тооцогдохгүй. Тиймээс гадаадын улс орны олон улсын байгууллагын төлөөлгчийн газрын оршин тогтнож буй эдийн засгийн нутаг дэвсгэр болон тэдгээрийн хоорондох гүйлгээ гадаад гүйлгээнд хамаарна. Дипломат, консулын газрын ажилтан, цэргийн баазын албан хаагчид болон тэдгээрийн гэр бүлийнхний оршин тогтнож буй эдийн засгийн нутаг дэвсгэр дээр зарцуулсан бүх зардал нь засгийн газрын бараа, үйлчилгээнд бүртгэгдэнэ.

### **Засгийн газрын бараа, үйлчилгээний орлого**

Бичилт: кредит: засгийн газрын бараа, үйлчилгээний орлого

дебит: цэвэр нөөц, нийт актив, бусад

Мэдээллийн эх үүсвэр: Харьяат бус элчин сайдын яам, төлөөлгчийн газрын зардлын мэдээ, гадаад гүйлгээний тайлан.

### **Засгийн газрын бараа, үйлчилгээний зардал**

Бичилт: дебит: засгийн газрын бараа, үйлчилгээний зардал

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Засгийн газрын санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Монгол улсын гадаад дахь элчин сайдын яам, төлөөлгчийн газрын зардлын мэдээ, гадаад гүйлгээний тайлан.

## **2.2 Анхдагч орлого**

Анхдагч орлогод харьяат, харьяат бусын хооронд үйлдвэрлэлийн үйл явцад орц буюу хөдөлмөр нийлүүлэх, санхүүгийн хөрөнгө эзэмших, байгалийн баялгийг түрээслэхтэй холбогдон гарсан ажил, гүйлгээ, түүний орлогыг хамааруулна.

Анхдагч орлогыг дараах 3төрөлд ангилна:

1. **Ажиллагчдын цалин.** харьяат бус ажиллагчдад (хилийн/боомтын, улирлын чанартай болон бусад богино хугацааны) төлсөн цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, албан хаагчдын үнэт цаасны опцион;
2. **Хөрөнгө оруулалтын орлого.** үйлдвэрлэлийн бус хөрөнгө, гадаад санхүүгийн актив, пассивт хүлээн авсан болон төлсөн хөрөнгө оруулалтын орлого;
3. **Бусад анхдагч орлого.** бүтээгдэхүүн болон үйлдвэрлэлийн татвар, татаас, түрээс.

### **2.2.1 Ажиллагчдын цалин хөлс**

Монгол Улсад байгаа гадаадын элчин сайдын яам, консулын газар, олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газарт ажилладаг монгол ажиллагчдын цалин, түүнтэй адилтгах орлогыг энд бүртгэнэ.

Ажиллагчдын нэрийн өмнөөс нийгмийн даатгалын санд төлөгдөгдөг даатгалын төлбөр, Монгол Улсын эдийн засгийн сонирхлын төвд ажилладаг хил/боомтын, улирлын эсвэл богино хугацааны (1 жилээс бага хугацаагаар) ажиллагчдын цалин, түүнтэй адилтгах орлогыг мөн энд оруулах бөгөөд дараах бичилт хийнэ. Үүнд:

#### **Ажиллагчдын цалин хөлсний орлого**

**Бичилт:** кредит: Ажиллагчдын цалин хөлсний орлого  
дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн (бусад холбогдох данс)

**Мэдээллийн эх үүсвэр:** Гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Монгол улсад байгаа гадаадын элчин сайдын яам, консулын газар, олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газар дахь монгол ажиллагчдын цалин түүнтэй адилтгах орлогын судалгаа.

#### **Ажиллагчдын цалин хөлсний зардал**

**Бичилт:** дебет: Ажиллагчдын цалин хөлсний зардал  
кредит: цэвэр нөөц, нийт актив, бусад актив (бусад гүйлгээний хамт шууд тавигдах тул кредит бичилтийг хийхгүй.)

**Мэдээллийн эх үүсвэр:** Гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Гадаад орнууд дахь Монгол улсын элчин сайдын яам, консулын газар дахь орон нутгийн ажиллагчдын цалин, түүнтэй адилтгах орлогын мэдээ.

### **2.2.2 Хөрөнгө оруулалтын орлого**

Энд харьяат ба харьяат бусын хооронд харилцан шилжүүлсэн ногдол ашиг, хуримтлагдсан ашиг (retained earnings), хүүгийн орлогыг бүртгэнэ. Энэ төрлийн гүйлгээг шууд хөрөнгө оруулалтын, багцын хөрөнгө оруулалтын, бусад хөрөнгө оруулалтын болон нөөцтэй холбоотой орлого гэсэн 4үндсэн бүлэгт хувааж бүртгэнэ.

Хуваарилсан ногдол ашиг (дивиденд) нь төлбөр ногдуулсан өдрөөр, хүүний орлого нь аккруэль сууриар бүртгэгдэнэ. Хэрэв хүүний орлого төлөгдөөгүй бол орлогын бичилтийг мөн төлөгдөөгүй байдлаар санхүүгийн дансанд бичилт хийнэ.

#### **2.2.2.1 Шууд хөрөнгө оруулалтын орлого**



Эдийн засгийн сонирхлын үүднээс нэг улсын харьяат аж ахуйн нэгж (хөрөнгө оруулагч) нь нөгөө улсын харьяат аж ахуйн нэгжид (хөрөнгө оруулалтыг хүлээн авагч) урт хугацаатайгаар нийлүүлсэн хөрөнгөнөөс орох орлогыг энд багтаана. Шууд хөрөнгө оруулалтын орлого нь хувь нийлүүлсэн хөрөнгөнд ногдох орлого, зээлийн хүүний орлого гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Шууд хөрөнгө оруулалтын орлогыггадагш хийсэн болон гадаадаас оруулсан шууд хөрөнгө оруулалтын цэвэр дүнгээр бичнэ (хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалт болон зээлийн хүүний орлогын дүнгээс хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалт болон зээлийн хүүний орлогын төлбөрийн дүнг хасаж тооцсоноор).

**2.2.2.1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгөд ногдох орлого.** Энд шууд хөрөнгө оруулалтад хуваарилсан ногдол ашиг (дивиденд), түүнээс хөрөнгө оруулалтанд буцааж оруулсан орлогыг бүртгэнэ. Бүртгэлийг цэвэр дүнгээр өөрөөр хэлбэл, харьяат бусаас шилжиж ирсэн орлогын дүнгээс харьяат буст төлсөн дүнг хасч цэвэр дүнг кредит, дебет талын аль нэг дээр бүртгэнэ.

Хэрвээ цэвэр дүн нэмэх тэмдэгтэй буюу гадаадаас орсон орлого илүү бол кредит талд бүртгэж орлогын бичилт хийнэ. Цэвэр дүн хасах тэмдэгтэй буюу гадаадад шилжүүлсэн орлого илүү бол дебет талд бүртгэж зарлагын бичилт хийнэ.

2.2.2.1.1.1 Шууд хөрөнгө оруулалтад хуваарилсан ногдол ашгийн орлого, зарлагын бичилтийг дараах байдлаар хийнэ. Үүнд:

**Ногдол ашгийн орлого:**

Бичилт: кредит: Шууд хөрөнгө оруулалтад хуваарилсан ногдол ашгийн орлого  
дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

**Ногдол ашгийн зардал:**

Бичилт: дебет: Шууд хөрөнгө оруулалтад хуваарилсан ногдол ашгийн зардал  
кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа

Ногдол ашгийн орлого нь дараах 3 хэлбэртэй байна. Үүнд:

1. Шууд хөрөнгө оруулагчид төлсөн ногдол ашиг
2. Толгой компанидаа оруулсан хөрөнгө оруулалтын буюу урвуу хөрөнгө оруулалтын ногдол ашиг
3. Шууд хөрөнгө оруулагчаас бусад хөрөнгө оруулалтын хамааралтай аж ахуйн нэгжид төлсөн ногдол ашиг
  - 3.1 Толгой компани нь харьяат
  - 3.2 Толгой компани нь харьяат бус
  - 3.3 Толгой компаний эдийн засгийн харьяалал тодорхойгүй

2.2.2.1.1.2 Хөрөнгө оруулалтанд буцааж оруулсан орлого болох орлогын дахин хөрөнгө оруулалтын орлого, зарлагын бичилтийг дараах байдлаар хийнэ. Үүнд:

**Орлогын дахин хөрөнгө оруулалтын орлого:**

Бичилт: кредит: Орлогын дахин хөрөнгө оруулалтын

орлого  
дебет: Санхүүгийн данс, шууд хөрөнгө оруулалт, гадаадад гарсан шууд хөрөнгө оруулалт

#### **Орлогын дахин хөрөнгө оруулалтын зардал:**

Бичилт: дебет: Орлогын дахин хөрөнгө оруулалтын зардал  
кредит: санхүүгийн данс, шууд хөрөнгө оруулалт, гадаадаас орсон шууд хөрөнгө оруулалт

Мэдээллийн эх үүсвэр: Гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа нь зээлийн хүүгийн орлого, зарлагын бичилт

2.2.2.1.2 **Зээлийн хүүний орлого.** Гадаадын хөрөнгө оруулалттай компани - хоорондын зээлийн хүүгийн орлого болон төлбөрийг бүртгэх бөгөөд бичилтийг цэвэр дүнгээр тусгана. Зээлийн хүүгийн орлого, зарлагын бичилтийг дараах байдлаар хийнэ. Үүнд:

##### **Зээлийн хүүний орлого**

Бичилт: кредит: зээлийн хүүний орлого  
дебет: гадаад валютын албан нөөц (бусад холбогдох санхүүгийн данс)

##### **Зээлийн хүүний зарлага**

Бичилт: дебет: зээлийн хүүний зарлага  
кредит: гадаад валютын албан нөөц (бусад холбогдох санхүүгийн данс)

Мэдээллийн эх үүсвэр: Гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа.

#### **2.2.2.2 Багцын хөрөнгө оруулалтын орлого**

Багцын хөрөнгө оруулалтын орлогод шууд хөрөнгө оруулалт болон нөөц активын орлогоос бусад хувьцаа, бонд, үнэт цаас, өрийн бичиг, мөнгөний захын хэрэгслэлийн хүү болон санхүүгийн деривативын гүйлгээнээс олсон хүүний орлогыг бүртгэнэ. Багцын хөрөнгө оруулалтын орлого нь хөрөнгийн хувьцаа, хөрөнгө оруулалтын санд хувь нийлүүлсэн хөрөнгийн орлого болон хүүгийн орлого (бонд, үнэт цаас, өрийн бичиг болон бусад мөнгөний хэрэгслийн хүү, санхүүгийн үүсмэл хэрэгслийн орлого гэх мэт) гэсэн 2 хэсгээс бүрдэнэ.

2.2.2.2.1 **Хөрөнгийн хувьцаа болон хөрөнгө оруулалтын санд хувь нийлүүлсэн хөрөнгийн орлого.** Энд хөрөнгийн хувьцааны ногдол ашиг, хөрөнгө оруулалтын санд хувь нийлүүлсэн хөрөнгийн ногдол ашиг (дивиденд) болон түүнээс буцааж хөрөнгө оруулалтын санд хувь нийлүүлсэн орлогыг бүртгэнэ. Харьяат бусад шилжүүлсэн зарлагын гүйлгээг дебет бичилтээр, харьяат бусаас хүлээж авсан орлогын гүйлгээг кредит бичилтээр бүртгэнэ.

##### **Хөрөнгийн орлого**

Бичилт: кредит: хөрөнгийн хувьцаа болон хөрөнгө оруулалтын санд хувь нийлүүлсэн хөрөнгийн орлого  
дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

##### **Хөрөнгийн зарлага**

Бичилт: дебет: хөрөнгийн хувьцаа болон хөрөнгө

оруулалтын санд хувь нийлүүлсэн хөрөнгийн зарлага

кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Төв банкны дэлгэрэнгүй тайлан тэнцэл, гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн төлбөрийн тэнцлийн мэдээ, арилжааны банкуудын төлбөрийн тэнцлийн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа.

**2.2.2.2.2 Хүүгийн орлого.** Энд бонд, өрийн бичиг, мөнгөний захын хэрэгслийн хүү, болон санхүүгийн деривативын гүйлгээнээс олсон хүүгийн орлогыг бүртгэнэ. Харьятаас харьяат бусад шилжүүлсэн зарлагын гүйлгээг дебет бичилтээр, харьяат бусаас хүлээж авсан орлогын гүйлгээг кредит бичилтээр бүртгэнэ. Зээлийн хүүний орлого, зарлагын дараах бичилтийг хийнэ. Үүнд:

#### **Өрийн бичгийн хүүгийн орлого**

Бичилт: кредит: хүүгийн орлого  
дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

#### **Өрийн бичгийн хүүгийн зарлага**

Бичилт: дебет: хүүгийн зарлага  
кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Төв банкны дэлгэрэнгүй тайлан тэнцэл, гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн төлбөрийн тэнцлийн мэдээ, арилжааны банкуудын төлбөрийн тэнцлийн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа.

#### **2.2.2.3 Хөрөнгө оруулалтын бусад орлого**

Энд Засгийн газар, Төвбанк, арилжааны банк, аж ахуйн нэгж, иргэдийн харьяат буст олгосон/авсан зээл, худалдааны санхүүжилт болон санхүүгийн лизингийн эх үүсвэрийн хүүгийн орлого/төлбөрийг бүртгэнэ. Мөн гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламжийн хүүгийн орлого, харьяат бусын харилцах, хадгаламжид төлсөн хүүний төлбөр, амь насны даатгалын нөөц болон тэтгэврийн сангийн хувь нийлүүлсэн хөрөнгөд ногдох өрхийн хийсвэр орлого хамаарна.

#### **Хөрөнгө оруулалтын бусад орлого**

Бичилт: кредит: бусад хөрөнгө оруулалтын орлого  
дебет: гадаад валютын албан нөөц (бусад холбогдох санхүүгийн данс)

#### **Хөрөнгө оруулалтын бусад зарлага**

Бичилт: дебет: бусад хөрөнгө оруулалтын зарлага  
кредит: гадаад валютын албан нөөц (бусад холбогдох санхүүгийн данс)

Мэдээллийн эх үүсвэр: Банкуудын гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, Төв банк, Засгийн газрын тайлан мэдээ.

#### **2.2.2.4 Гадаад валютын албан нөөцийн орлого**

Энэхүү дансанд гадаад валютын албан нөөцөөс хөрөнгө, хөрөнгө оруулалтын санд оруулсан хөрөнгийн орлого болон хүүгийн орлогыг тусгана. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын гадаад валютын албан нөөцийг зөвхөн харилцах, хадгаламж, үнэт

цаасны хэлбэрээр байршуулж байгаа тул гадаад валютын албан нөөцийн орлогод зөвхөн эдгээр активын хүүгийн орлого бүртгэгдэнэ.

ОУВС-гаас Монгол Улсад хуваарилсан зээлжих тусгай эрхийн хуваарилалтын хүүгийн төлбөр нь энэ дансанд тусгагдахгүй, бусад хөрөнгө оруулалтын орлогын дансанд орно.

### 2.2.3 Бусад анхдагч орлого

Энэ дансанд бүтээгдэхүүн болон импортын татвар, татаас, түрээс, түүнтэй адилтгахгүйлгээг бүртгэх бөгөөд дараах тусгааройлгоно. Үүнд:

Бүтээгдэхүүн болон импортын татвар, татаасанд гэж бараа болон үйлчилгээний нэмүү өртгийн албан татвар, импортын хураамж, экспортын татвар, онцгой албан татвар, цалингийн шимтгэл, барилга, газар, бизнесийн лицензийн албан татвар болон түүнтэй ижил төрлийн татаасыг бүртгэх бөгөөд харин орлогын албан татвар, хөрөнгийн татвар, ногдол ашигт ноогдуулсан татварыг оруулахгүй.

Түрээс гэж харьяат болон харьяат бусын хооронд хийсэн байгалийн баялаг, ашигт малтмал болон бусад газар доорх баялаг ашигласны төлбөр, загасчлал, ойн аж ахуй болон бэлчээр ашиглах эрхийн төлбөр зэргийг ойлгоно.

Бусад анхдагч орлого хүлээн авах болон гадагш шилжүүлэхэд дараах бичилтийг хийнэ. Үүнд:

#### **Бусад анхдагч орлого хүлээн авах**

Бичилт: кредит: бусад анхдагч орлого  
дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн (бусад холбогдох санхүүгийн данс)

#### **Бусад анхдагч орлого гадагш шилжүүлэх**

Бичилт: дебет: бусад анхдагч орлого  
кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн (бусад холбогдох санхүүгийн данс)

Мэдээллийн эх үүсвэр: Гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн төлбөрийн тэнцлийн мэдээ, банкуудын төлбөрийн тэнцлийн мэдээ.

### 2.3 Хоёрдогч орлого

Хоёрдогч орлого гэж харьяат болон харьяат бусын хооронд хийсэн урсгал шилжүүлгийг ойлгоно. Урсгал шилжүүлэгт бодит нөөц болон санхүүгийн хэрэгслийг солилцож буй гүйлгээнээс бусад төрлийн нэг талт гүйлгээг багтаана. Урсгал шилжүүлэг нь татвар төлсний дараах орлогод шууд нөлөөлж, бараа, үйлчилгээний хэрэглээнд өөрчлөлт оруулна.

Урсгал шилжүүлэг нь хандивлагчийн боломжит орлого, хэрэглээг бууруулж, харин хүлээн авагчийн орлого, хэрэглээг нэмэгдүүлэх бөгөөд биет ба мөнгөн хэлбэрээр илэрхийлэгдэнэ. Мөнгөн шилжүүлгийг ямар нэгэн үндсэн хөрөнгө худалдан авах зориулалтаар хийсэн бол түүнийг хөрөнгийн шилжүүлэгт бүртгэнэ.

Урсгал шилжүүлгийг Засгийн газрын шилжүүлэг болон бусад гэсэн хоёр үндсэн бүлэгт ангилж бүртгэнэ.

### **2.3.1 Засгийн газрын шилжүүлэг**

#### **Орлогын албан татвар**

Энэхүү албан татварт харьяат бусын хөдөлмөр болон санхүүгийн хөрөнгөөс олсон ашиг орлогод ногдуулж буй бүх төрлийн татвар орох ба цалин хөлс, хүүгийн орлого, ногдол ашиг, үнэт цаас худалдан авах болон худалдах үйл ажиллагаа зэрэгт ногдуулсан татвар зэргийг бүртгэнэ. Түүнчлэн үйлчилгээнд үл хамаарах, Засгийн газраас олгож буй тусгай зөвшөөрөл, лицензийн хураамжийг энэхүү татварт оруулна. Татварыг цаг хугацаанд нь төлөөгүйтэй холбогдох торгуулийг мөн энд хамааруулан бүртгэнэ. Монгол Улсын эдийн засгийн сонирхлын төвд ажилладаг хил/боомтын, улирлын эсвэл богино хугацааны (1 жилээс бага хугацаагаар) ажиллагчдын цалин болон түүнтэй адилтгах орлогод ногдуулсан татварыг дэд ангилалд тусгана.

#### **Нийгмийн даатгал**

Харьяат бусын нийгмийн даатгал, тэтгэврийн санд төлж буй шимтгэлийн орлого болон харьяат буст олгосон ажилгүйдэл, эрүүл мэндийн нөхөн олговрын зардлыг бүртгэнэ. Түүнчлэн Монгол Улсын эдийн засгийн сонирхлын төвд ажилладаг хил/боомтын, улирлын эсвэл богино хугацааны (1 жилээс бага хугацаагаар) ажиллагчдын нийгмийн даатгалыг дэд ангилалд тусгана.

#### **Олон улсын хамтын ажиллагааны шилжүүлэг**

Засгийн газар хоорондын болон Засгийн газар, олон улсын байгууллага хоорондын урсгал шилжүүлгийг бүртгэнэ. Үүнд:

- төсвийн урсгал зардлыг санхүүжүүлэх зориулалтаар олгосон мөнгөн тусламж,
- байгалийн болон бусад гамшгийг даван туулах зориулалтаар олгосон бүх төрлийн барааны хандив, эмнэлгийн хэрэгслэлийн тусламж,
- олон улсын байгууллагын гишүүнчлэлийн татвар, олон улсын байгууллагаас гишүүний асуудлаар засгийн газарт шилжүүлсэн шилжүүлэг,
- зэр зэвсэг, холбогдох тоног төхөөрөмж зэрэг зарим цэргийн тоног төхөөрөмжийн хандив,
- олон улсын байгууллага, гадаадын засгийн газрын техник туслалцааны хүрээнд ажиллагчдын цалин, бусад холбогдох зардлын санхүүжилт;

#### **Засгийн газрын бусад шилжүүлэг**

Дээрх ангилалд үл хамаарах Засгийн газрын шилжүүлгийг бүртгэх ба Засгийн газраас ашгийн бус үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудад шилжүүлсэн мөнгөн дүнг ялган харуулна.

Орлогын татвар болон нийгмийн даатгалын төлбөр зэрэг бусад шилжүүлгийг Засгийн газрын шилжүүлгийн кредит талд, нийгмийн халамж, татварын буцаан олголт, нөхөн төлбөр, тэтгэвэр олголтыг дебет талд бичнэ. Засгийн газрын орлогын дебет бичилт нь цэвэр нөөцийн нийт актив, бусад актив гэсэн бүлэгт шууд тусгагдаж, харин Засгийн газрын орлогын дебет бичилтийг энд хийхгүй. Засгийн газрын шилжүүлгийн орлого, зарлагын дараах бичилтийг хийнэ. Үүнд:

#### **Засгийн газрын шилжүүлгийн орлого**

Бичилт: кредит: Засгийн газрын шилжүүлэг

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын статистикийн мэдээ, Засгийн газрын санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын техник туслалцааны ашиглалтын мэдээ, Төв банк, Засгийн газрын санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Засгийн газарт олон улсын байгууллагаас шилжүүлсэн шилжүүлгийн мэдээ.

## **Засгийн газрын шилжүүлгийн зарлага**

**Бичилт:** дебет: Засгийн газрын шилжүүлэг  
кредит: цэвэр нөөц, нийт актив, бусад актив, бусад гүйлгээний дүнтэй хамт бичигдэнэ.

**Мэдээллийн эх үүсвэр:** Төв банк, Засгийн газрын санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Олон улсын байгууллагад төлсөн гишүүнчлэлийн төлбөрийн мэдээ.

### **2.3.2 Санхүүгийн болон санхүүгийн бус байгууллага, өрх, ашгийн төлөө бус байгууллагын шилжүүлэг**

Энэ хэсэгт Засгийн газраас бусад субъектүүдийн урсгал шилжүүлгийг бүртгэнэ.

#### **1. Хувийн шилжүүлэг**

Эдийн засгийн харьяалал ялгаатай өрхүүдийн хооронд хийгдэж буй шилжүүлгийг авч үзэх бөгөөд энд уг шилжүүлж буй орлогын эх үүсвэр, өрх хоорондын хамаарлыг авч үзэхгүй. Ажиллагчдын гуйвуулгыг нийт хувийн шилжүүлгээс салган авч үзнэ.

**Ажиллагчдын гуйвуулга.** Гуйвуулга гэдэгт мөнгөн болон биет хэлбэрийн гуйвуулгыг ойлгож, кредит талд гадаад орнуудад 1 ба түүнээс дээш жилээр ажиллаж буй Монгол иргэдээс Монгол Улс руу илгээсэн гуйвуулгыг, дебет талд Монгол Улсад 1 ба түүнээс дээш хугацаагаар ажиллаж буй гадаадын иргэдийн гадаад орнууд руу шилжүүлсэн гуйвуулгыг бүртгэнэ. Ажиллагчдын гуйвуулгын орлого, зарлагын дараах бичилтийг хийнэ. Үүнд:

#### **Ажиллагчдын гуйвуулгын орлого**

**Бичилт:** кредит: ажиллагчдын гуйвуулгын орлого  
дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

**Мэдээллийн эх үүсвэр:** Шуудангийн үйл ажил ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн Илгээмжийн мэдээ, Гадаад гүйлгээний тайлан, Банк бус санхүүгийн байгууллагын гадаад гүйлгээний тайлан, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Ажиллах хүч, хөдөлмөр эрхлэлтэд зуучлагч компаниудын гадаадад гэрээгээр ажиллаж буй монгол иргэдийн мэдээ, гадаадад ажиллаж буй Монгол иргэдийн судалгаа.

#### **Ажиллагчдын гуйвуулгын зарлага**

**Бичилт:** дебет: ажиллагчдын гуйвуулгын зарлага  
кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

**Мэдээллийн эх үүсвэр:** Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын гадаад ажиллагчдын цалингийн мэдээ, Шуудангийн үйл ажил ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн илгээмжийн мэдээ.

#### **2. Бусад урсгал шилжүүлэг.**

Бусад шилжүүлэгт дараах гүйлгээг хамруулж, бүртгэнэ.

- Хөрөнгө, орлогын албан татвар,
- Нийгмийн даатгалын шимтгэл болон нөхөн олговор,
- Амь насны бус даатгалын хураамж, нөхөн төлбөр(цэвэр дүнгээр),
- Олон улсын байгууллагын гишүүний татвар, хамтын ажиллагааны санхүүжилт
- Дээр дурьдагдсанаас бусад дараах зүйлийг хамааруулна:

- олон улсын улаан загалмайн байгууллага, гадаад орнуудын шашин болон сайн дурын, урлаг соёлын байгууллагын шугамаар байгалийн болон бусад гамшгийг даван туулах зориулалтаар олгосон бүх төрлийн барааны хандив, эмнэлгийн хэрэгслийн тусламж, мөнгөн хандив,
- гадаад орнуудад зохиогдсон спорт, урлагийн болон бусад тэмцээн, уралдааны шагнал, сугалааны хонжворын шагнал, бусад шагнал,
- олон улсын болон гадаадын төрийн бус байгууллагуудад шилжүүлсэн гишүүнчлэлийн хураамж, хандивын шилжүүлэг,
- гадаад орнуудад болох спорт, урлагийн болон бусад тэмцээн, уралдааны тасалбарын Монгол Улсад борлуулсан орлого зэрэг болно.

Бусад шилжүүлэг нь цэвэр нөөцийн нийт актив, бусад актив гэсэн бүлэгт шууд тусгагдах тул Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын орлогын кредит бичилт энд хийгдэхгүй. Бусад шилжүүлгийн орлого, зарлагын дараах бичилтийг хийнэ. Үүнд:

#### **Бусад шилжүүлгийн орлого**

Бичилт: кредит: бусад шилжүүлгийн орлого  
дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Байгаль, орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Гадаадын анчдын төлсөн хураамжийн мэдээ, Боловсрол, соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Гадаадын уралдаан, тэмцээнд Монгол иргэдийн авсан шагналын мэдээ, олон улсын улаан загалмайн байгууллага, гадаадын төрийн бус байгууллагын шугамаар ирсэн хандив, тусламжийн судалгаа.

#### **Бусад шилжүүлгийн зарлага**

Бичилт: дебет: бусад шилжүүлгийн зарлага  
кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Олон улсын улаан загалмайн байгууллага ба гадаадын төрийн бус олон нийтийн байгууллагад шилжүүлсэн гишүүнчлэл, хандивын төлбөрийн судалгаа.

### **3. Хөрөнгийн данс**

Хөрөнгийн дансны гүйлгээг хөрөнгийн шилжүүлэг болон үйлдвэрлэгдэггүй, санхүүгийн бус активын шилжүүлэг гэсэн хоёр ангиллаар бүртгэнэ.

#### **3.1 Хөрөнгийн шилжүүлэг**

Үндсэн хөрөнгийн өмчлөгч эзэн өөрчлөгдсөн, зээлийг хүчингүй болгосноор өглөг зээлдэгчийн мэдэлд шилжсэн болон үндсэн хөрөнгө худалдан авахаар шилжүүлсэн бэлэн мөнгө, элчин сайдын яам, олон улсын байгууллагын эзэмшилд шилжүүлсэн газрын шилжүүлгийн гүйлгээ энд багтана. Хөрөнгийн шилжүүлгийн ангилал нь ҮТС-д бүрэн нийцсэн байна.

Хөрөнгийн шилжүүлэг нь биет болон мөнгөн хэлбэрээр хийгдэж болно.

Биет хэлбэрийн хөрөнгийн шилжүүлэгт 1) үндсэн хөрөнгийн өмчлөлийг шилжүүлэх; 2) зээлдүүлэгч болон зээлдэгчийн 2 талын гэрээгээр зээлдүүлэгч тал нь зээлдэгчийнхээ өрийг хүчингүй болгох зэрэг шилжүүлэг багтана.

Хөрөнгийн шилжүүлгийг Засгийн газар болон бусад гэсэн ангиллаар бүртгэж, бусад секторт Төв банк, хадгаламжийн байгууллага, аж ахуйн нэгжийг нэгтгэж харуулна. Засгийн газар болон бусад секторт хүчингүй болгосон өрийг аль алинд нь тусгаж, харин шилжин суугчдын хөрөнгийн шилжүүлгийг бусад секторт тусгана.

**1. Засгийн газар.** Засгийн газрын хөрөнгийн шилжүүлэг нь Засгийн газрын хүчингүй болгосон өр, газрын хөрөнгийн шилжүүлгээс бүрдэнэ.

Хэрэв Монгол Улсын Засгийн газар зээлдүүлэгч бол харьяат бус зээлдэгчид гэрээний дагуу хөрөнгийг шилжүүлэх буюу харьяат бус зээлдүүлэгчээс Монгол Улсын Засгийн газарт гэрээний дагуу хөрөнгийг шилжүүлсэн тохиолдолд хөрөнгийн шилжүүлгийн бүртгэлийг хийнэ.

**1.1. Хүчингүй болгосон өр.** Хоёр тал харилцан тохиролцсоны үндсэн дээр зээлийн өрийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хүчингүй болгосон тохиолдолд зээлдэгч орлогын гүйлгээ хийж, харин зээлдүүлэгчийн тал зарлагын гүйлгээний дараах бичилтийг хийнэ. Үүнд:

**Хүчингүй болгосон өрийн орлого**

Бичилт: кредит: хүчингүй болгосон өрийн орлого  
дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, пассив, зээл, засгийн газар

Мэдээллийн эх үүсвэр: Засгийн газрын хүчингүй болгосон өрийн мэдээ.

**Хүчингүй болгосон өрийн зарлага**

Бичилт: дебет: хүчингүй болгосон өрийн зарлага  
кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, пассив, зээл, засгийн газар

Мэдээллийн эх үүсвэр: Засгийн газрын санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Засгийн газрын хүчингүй болгосон өрийн мэдээ.

**1.2. Газар.** Монгол Улсад суугаа гадаад орны элчин сайдын яам, олон улсын байгууллагын эзэмшилд шилжсэн газрын төлбөрийг орлого талд, харин гадаад орнуудад суугаа Монголын элчин сайдын яамны худалдан авсан газрын төлбөрийг зарлага талд бүртгэнэ. Газрын орлогын дебет болон газрын зарлагын кредит гүйлгээний бичилтийг энд хийхгүй. Газрын орлого, зарлагын дараах бичилтийг хийнэ. Үүнд:

**Газрын орлого:**

Бичилт: кредит: Газрын орлого  
дебет: цэвэр нөөц, нийт актив, бусад актив

**Газрын зарлага:**

Бичилт: дебет: Газрын зарлага  
кредит: цэвэр нөөц, нийт актив, бусад актив

Мэдээллийн эх үүсвэр: Гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын газрын мэдээ.

**1.3. Бусад.** Засгийн газрын хөрөнгийн шилжүүлгэнд хөрөнгө оруулалтын тусламжийн шилжүүлэг голлон хийгдэнэ. Хөрөнгийн хуримтлалыг бий болгодог барилгын төсөл байх бөгөөд хөрөнгө оруулалтын төсөл урт хугацаанд үргэлжилбэл, энэ хэмжээгээр бэлэн төлөгдсөн төлбөр хийгдэж болно. Энэ гүйлгээг хөрөнгийн шилжүүлгээр мөн бүртгэнэ. Засгийн газрын хөрөнгийн биет шилжүүлэг нь тээврийн хэрэгсэл, машин, тоног төхөөрөмж болон барилга, байгууламжийг харьяат буст шилжүүлсэн хөрөнгийн шилжүүлэг байна. Бусад хөрөнгийн шилжүүлгийн орлого, зарлагын дараах бичилтийг хийнэ. Үүнд:

**Бусад хөрөнгийн шилжүүлгийн орлого**

Бичилт: кредит: Засгийн газрын бусад шилжүүлгийн орлого



дебет: цэвэр нөөц, нийт актив, бусад актив

**Бусад хөрөнгийн шилжүүлгийн зарлага**

Бичилт: дебет: Засгийн газрын бусад шилжүүлгийн зарлага

кредит: цэвэр нөөц, нийт актив, бусад актив

Мэдээллийн эх үүсвэр: Засгийн газрын хөрөнгийн шилжүүлгийн мэдээ.

**2. Бусад сектор.** Засгийн газраас бусад секторт хамаарах харьяат, харьяат бусын хооронд хийгдэх хөрөнгийн шилжүүлэг болон шилжин суугчдын шилжүүлэг, хүчингүй болгосон өр болон бусад хөрөнгийн шилжүүлгийг энд багтана.

**2.1. Шилжин суугчдын шилжүүлэг.** Гадаад орнуудад шилжин суугчдийн шилжүүлгийг төлбөрийн тэнцэлд зарлагын гүйлгээгээр дебет талд бүртгэж, манай оронд шилжин суугчдынхыг орлогод бүртгэж, кредит бичилт хийнэ.

**2.1.1. Гэр ахуйн ба хувийн хэрэглээний эд зүйлс, хөдлөх хөрөнгө.**

Гэр ахуйн ба хувийн хэрэглээний эд зүйлс, хөдлөх хөрөнгө болон экспортын барааны хувьд гаалийн статистикийн мэдээнд тусгагдах тул дебет бичилтийг хийхгүй. Гэр ахуйн ба хувийн хэрэглээний эд зүйлс, хөдлөх хөрөнгийн орлого, зарлагын дараах бичилтийг хийнэ. Үүнд:

**Шилжин суугчдын гэр ахуйн ба хувийн хэрэглээний эд зүйлс, хөдлөх хөрөнгийн шилжүүлгийн орлого**

Бичилт: кредит: шилжин суугчдын гэр ахуйн ба хувийн хэрэглээний эд зүйлс, хөдлөх хөрөнгийн шилжүүлгийн орлого

дебет: импортын барааны бусад гүйлгээ

Мэдээллийн эх үүсвэр: Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гадаад худалдааны барааны мэдээ.

**Шилжин суугчдын гэр ахуйн ба хувийн хэрэглээний эд зүйлс, хөдлөх хөрөнгийн шилжүүлгийн зарлага**

Бичилт: дебет: шилжин суугчдын гэр ахуйн ба хувийн хэрэглээний эд зүйлс, хөдлөх хөрөнгийн шилжүүлгийн зарлага

кредит: экспортын барааны бусад гүйлгээ

Мэдээллийн эх үүсвэр: Засгийн газрын хөрөнгийн шилжүүлгийн мэдээ.

**2.1.2. Санхүүгийн хөрөнгө.** Энд шилжин суугчдын санхүүгийн хөрөнгийн шилжүүлгийн орлого, зарлагыг бүртгэж, дараах бичилтийг хийнэ. Үүнд:

**Шилжин суугчдын санхүүгийн хөрөнгийн шилжүүлгийн орлого**

Бичилт: кредит: хөрөнгийн данс, хөрөнгийн шилжүүлэг, бусад салбар, шилжин суугчдын шилжүүлэг

дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

### **Шилжин суугчдын санхүүгийн хөрөнгийн шилжүүлгийн зарлага**

**Бичилт:** кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах  
дебет: хөрөнгийн данс, хөрөнгийн шилжүүлэг, бусад салбар, шилжин суугчдын шилжүүлэг

Мэдээллийн эх үүсвэр: Гадаад гүйлгээний тайлан.

2.2. **Хүчингүй болгосон өр.** 1.1-т тусгасан Засгийн газрын хүчингүй болгосон өрийн гүйлгээтэй ижил зарчмаар бичилт хийнэ.

#### **Хүчингүй болгосон өрийн орлого**

**Бичилт:** кредит: хүчингүй болгосон өрийн орлого  
дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, пассив, зээл, бусад салбар

#### **Хүчингүй болгосон өрийн зарлага**

**Бичилт:** дебет: хүчингүй болгосон өрийн зарлага  
кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, пассив, зээл, бусад салбар

Мэдээллийн эх үүсвэр: Засгийн газрын санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хүчингүй болгосон өрийн судалгаа.

### **3.2 Үйлдвэрлэгдэхгүй, санхүүгийн бус хөрөнгө**

Энд үйлдвэрлэгдэхгүй, санхүүгийн бус актив хөрөнгө, худалдааны тэмдэгт, зохиогчийн эрх, патент, технологийг худалдан авсан, худалдсантай холбоотой шилжүүлгийн гүйлгээг бүртгэж, дараах бичилт хийнэ. Үүнд:

#### **Үйлдвэрлэгдэхгүй, санхүүгийн бус хөрөнгийн шилжүүлгийн орлого**

**Бичилт:** кредит: хөрөнгийн данс, үйлдвэрлэгдэхгүй санхүүгийн бус хөрөнгө  
дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцахын дүн

Мэдээллийн эх үүсвэр: Гадаад гүйлгээний тайлан, Оюуны өмчийн газрын Оюуны өмчийн эрх худалдсан орлогын мэдээ.

#### **Үйлдвэрлэгдэхгүй, санхүүгийн бус хөрөнгийн шилжүүлгийн зарлага**

**Бичилт:** кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах  
дебет: хөрөнгийн данс, үйлдвэрлэгдэхгүй санхүүгийн бус хөрөнгө

Мэдээллийн эх үүсвэр: Гадаад гүйлгээний тайлан.

## **4. Санхүүгийн данс**

Санхүүгийн дансны бүлэгт тухайн эдийн засгийн гадаад актив, пассивын гүйлгээг бүртгэдэг бүх данс хамаарна. Гадаад актив нь мөнгөжсөн алт, зээлжих тусгай эрхийн харилцах данс, харьяат бусаас авах авлагын дансаас бүрдэнэ. Гадаад пассив нь харьяат буст төлөх өглөгийг харуулна.

Энэ бүлгийн гүйлгээг шууд хөрөнгө оруулалт, багцын хөрөнгө оруулалт, санхүүгийн үүсмэл хэрэгсэл, бусад хөрөнгө оруулалт гэсэн 4 ангиллаар бүртгэнэ. Санхүүгийн данс нь бодит нөөцийг (тухайлбал, бүтээгдэхүүн, үйлчилгээ гэх мэт) солилцож буй гүйлгээний үед урсгал данстай, үйлдвэрлэдэггүй санхүүгийн бус активыг (патент, барааны тэмдэгт, технологи гэх мэт) солилцож буй гүйлгээний үед хөрөнгийн данстай,

санхүүгийн бүтээгдэхүүнийг хооронд нь солилцож буй гүйлгээний үед өөр бусад санхүүгийн данстайгаа тус тус харьцана.

#### 4.1 Шууд хөрөнгө оруулалт

Шууд хөрөнгө оруулалт гэж харьяат бус нь нэг ба түүнээс дээш жилийн хугацаанд үйл ажиллагааны удирдлагад нөлөөлөхүйц саналын эрх бүхий хэмжээний хөрөнгийг харьяат аж ахуйн нэгжид нийлүүлэх, салбар ба харьяа нэгжээ байгуулах үйл ажиллагааг хэлнэ. Энд анхны хөрөнгө оруулалтаас хойш хөрөнгө оруулагчаас нэмж нийлүүлсэн хөрөнгийг мөн хамруулна.

Төлбөрийн тэнцэлд шууд хөрөнгө оруулалтын хэмжээг аж ахуйн нэгжийн бүртгэлээр бус, бодит гүйцэтгэлээр бүртгэнэ. Монгол Улсад оруулсан гадаадын хөрөнгө оруулалтыг орлогын бичилтээр, гадаадад нийлүүлсэн хөрөнгө оруулалтыг зарлагын бичилтээр харуулна.

##### 4.1.1 Гадаадад оруулсан шууд хөрөнгө оруулалт (Актив)

###### 4.1.1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө

Энд гадаадад гаргасан хөрөнгө оруулагчийн анхны нийлүүлсэн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгөд хуваарилагдсан ногдол ашгийг буцааж оруулсан хөрөнгө, гаднаас нэмж оруулсан хөрөнгийг тус тус бүртгэнэ. Хувь нийлүүлсэн хөрөнгө нь бараа материал, тоног төхөөрөмж, эд зүйлс зэрэг биет болон мөнгөн хэлбэрээр байна.

###### 1.1.1.1 Бараа, материал, тоног төхөөрөмж, эд зүйлсийн орлого.

Бичилт: дебет: санхүүгийн данс, шууд хөрөнгө оруулалт, гадаадад гарсан, хувь нийлүүлсэн хөрөнгө

кредит: урсгал данс, бараа ба үйлчилгээ, бараа, экспорт, бусад

Мэдээллийн эх үүсвэр: Гадаад гүйлгээний тайлан, Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Гаалийн гадаад худалдааны барааны статистикийн мэдээ, Гадаадын худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын газрын Гадаадын шууд хөрөнгө оруулалтын мэдээ, Аж ахуйн нэгжийн судалгаа.

###### 1.1.1.1 Бэлэн мөнгө.

###### Бэлэн мөнгөний орлого

Бичилт: дебет: санхүүгийн данс, шууд хөрөнгө оруулалт, гадаадад гарсан, хувь нийлүүлсэн хөрөнгө

кредит: гадаад валютын албан нөөц (бусад холбогдох санхүүгийн данс)

Мэдээллийн эх үүсвэр: Гадаад гүйлгээний тайлан, Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Гаалийн гадаад худалдааны барааны статистикийн мэдээ, Гадаадын худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын газрын Гадаадын шууд хөрөнгө оруулалтын мэдээ, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн тайлан, аж ахуйн нэгжийн судалгаа.

###### Бэлэн мөнгөний зарлага

Бичилт: кредит: санхүүгийн данс, шууд хөрөнгө оруулалт, гадаадаас орсон, хувь нийлүүлсэн хөрөнгө

дебет: гадаад валютын албан нөөц (бусад холбогдох санхүүгийн данс)

Мэдээллийн эх үүсвэр:Гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн тайлан, аж ахуйн нэгжийн судалгаа.

#### **4.1.1.2 Орлогын дахин хөрөнгө оруулалт**

Хөрөнгө оруулалтанд буцааж оруулсан орлогын бичилтийг дараах байдлаар хийнэ.

Бичилт: дебет: санхүүгийн данс, шууд хөрөнгө оруулалт, гадаадаас орсон шууд хөрөнгө оруулалт, орлогын дахин хөрөнгө оруулалт  
кредит: урсгал данс, орлого, орлогын дахин хөрөнгө оруулалтын орлого

Мэдээллийн эх үүсвэр:Гадаад гүйлгээний тайлан, орлого үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа, санхүүгийн тайлан нь зээлийн хүүгийн орлого, зарлагын бичилт.

#### **4.1.1.3 Бусад хөрөнгө**

Шууд хөрөнгө оруулагч болон хөрөнгө оруулалтын хамааралтай компани (харьяат)-аас харьяат буст олгосон зээлийн хөрөнгийг бүртгэнэ.

##### **Салбар компаниас авах**

Бичилт: дебет: санхүүгийн данс, шууд хөрөнгө оруулалт, гадаадаас орсон, бусад хөрөнгө  
кредит: гадаад валютын албан нөөц (бусад холбогдох санхүүгийн данс)

##### **Салбар компанид өгөх**

Бичилт: кредит: санхүүгийн данс, шууд хөрөнгө оруулалт, гадагшаа гарсан, бусад хөрөнгө  
дебет: гадаад валютын албан нөөц (бусад холбогдох санхүүгийн данс)

Мэдээллийн эх үүсвэр:Гадаад гүйлгээний тайлан, Гадаадын шууд хөрөнгө оруулалтын мэдээ, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн тайлан, аж ахуйн нэгжийн судалгаа.

### **4.1.2 Гадаадаас орсон шууд хөрөнгө оруулалт (Пассив)**

#### **4.1.2.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө**

Энд хөрөнгө оруулагчийн анхны нийлүүлсэн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгөд хуваарилагдсан ногдол ашгийг буцааж оруулсан хөрөнгө, гаднаас нэмж оруулсан хөрөнгийг энд бүртгэнэ. Хувь нийлүүлсэн хөрөнгө нь бараа, материал, тоног төхөөрөмж, эд зүйлс зэрэг биет болон мөнгөн хэлбэрээр байна.

##### **1.1.1. Бараа материал, тоног төхөөрөмж, эд зүйлсийн орлого**

Бичилт: кредит: санхүүгийн данс, шууд хөрөнгө оруулалт, гадаадаас орсон, хувь нийлүүлсэн хөрөнгө  
дебет: урсгал данс, бараа ба үйлчилгээ, бараа, импорт, бусад

Мэдээллийн эх үүсвэр:Гадаад гүйлгээний тайлан, Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Гаалийн гадаад худалдааны барааны статистикийн мэдээ, Гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын газрын Гадаадын шууд хөрөнгө оруулалтын мэдээ, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн тайлан, аж ахуйн нэгжийн судалгаа.

**1.1.2. Бэлэн мөнгө.** Бэлэн мөнгөний орлого, зарлагын дараах бичилтийг хийнэ. Үүнд:

##### **Бэлэн мөнгөний орлого**

Бичилт: кредит: санхүүгийн данс, шууд хөрөнгө

оруулалт, гадаадаас орсон, хувь нийлүүлсэн хөрөнгө

дебет: гадаад валютын албан нөөц (бусад холбогдох санхүүгийн данс)

#### **Бэлэн мөнгөний зарлага**

Бичилт: дебет: санхүүгийн данс, шууд хөрөнгө оруулалт, гадаадаас орсон, хувь нийлүүлсэн хөрөнгө

кредит: гадаад валютын албан нөөц (бусад холбогдох санхүүгийн данс)

Мэдээллийн эх үүсвэр:Гадаад гүйлгээний тайлан, Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Гаалийн гадаад худалдааны барааны статистикийн мэдээ, Гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын газрын Гадаадын шууд хөрөнгө оруулалтын мэдээ, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн тайлан, аж ахуйн нэгжийн судалгаа.

#### **1.2. Орлогын дахин хөрөнгө оруулалт.**

Хөрөнгө оруулалтанд буцааж оруулсан орлогын бичилтийг дараах байдлаар хийнэ. Үүнд:

Бичилт: кредит: санхүүгийн данс, шууд хөрөнгө оруулалт, гадаадаас орсон шууд хөрөнгө оруулалт, орлогын дахин хөрөнгө оруулалтын орлого

дебет: урсгал данс, орлого, орлогын дахин хөрөнгө оруулалтын орлого

Мэдээллийн эх үүсвэр:Гадаад гүйлгээний тайлан, орлого, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн тайлан, аж ахуйн нэгжийн судалгаа, санхүүгийн тайлан нь зээлийн хүүгийн орлого, зарлагын бичилт.

#### **1.3. Бусад хөрөнгө.**Гадаадын шууд хөрөнгө оруулагч болон хөрөнгө оруулалтын хамааралтай компани (харьяат бус)-аас харьяатын авсан зээлийн хөрөнгийг бүртгэнэ.

##### **Хөрөнгө оруулагчаас авах**

Бичилт: кредит: санхүүгийн данс, шууд хөрөнгө оруулалт, гадаадаас орсон, бусад хөрөнгө

дебет: гадаад валютын албан нөөц (бусад холбогдох санхүүгийн данс)

##### **Хөрөнгө оруулагчид өгөх**

Бичилт: дебет: санхүүгийн данс, шууд хөрөнгө оруулалт, гадагшаа гарсан, бусад хөрөнгө

кредит: гадаад валютын албан нөөц (бусад холбогдох санхүүгийн данс)

Мэдээллийн эх үүсвэр:Гадаад гүйлгээний тайлан, Гадаадын шууд хөрөнгө оруулалтын мэдээ, аж ахуйн нэгжийн улирлын нэгдсэн тайлан, аж ахуйн нэгжийн судалгаа.

## **4.2 Багцын хөрөнгө оруулалт**

Багцын хөрөнгө оруулалт гэж харьяат ба харьяат бусын хооронд хийгдсэн, шууд хөрөнгө оруулалт болон гадаад валютын албан нөөцөд бүртгэснээс бусад бүх төрлийн үнэт цаас, өрийн бичгийг хэлнэ. Багцын хөрөнгө оруулалтын гүйлгээг “хөрөнгийн хувьцаа болон хөрөнгө оруулалтын санд хувь нийлүүлсэн хөрөнгө” болон “өрийн бичиг” гэсэн 2 үндсэн төрлөөр, эдийн засгийн дөрвөн бүлгээр (Төв банк, Засгийн газар, Хадгаламжийн байгууллага ба Бусад сектор) ангилж бүртгэнэ. “Хөрөнгийн хувьцаа болон хөрөнгө оруулалтын санд хувь нийлүүлсэн хөрөнгө”-ийг тусад нь бүртгэх бөгөөд дор дурдсан утгаар ойлгоно.

“Хөрөнгийн хувьцаа” гэж хувь нийлүүлсэн байгууллагын хөрөнгийн тодорхой хэсгийг эзэмшихийг баталгаажуулсан эрхийн бичиг болон түүнтэй адилтгах бүх төрлийн үнэт цаасыг;

“Хөрөнгө оруулалтын санд хувь нийлүүлсэн хөрөнгө” гэж хөрөнгө оруулалтын сан болон түүнтэй адилтгах санд оруулсан хувьцаа, нэгж эрхийг;

“Өрийн бичиг” гэж үнэт цаас гаргагчаас тогтоосон хугацаанд түүнийг эзэмшигчид үндсэн төлбөр болон хүүг эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн бонд, өрийн бичигболон түүнтэй адилтгах бусад үнэт цаасыг ойлгоно.

**1. Актив.**Актив данс нь харьяат бусаас авах авлагыг харуулна.Засгийн газар, Монголбанкны багцын хөрөнгө оруулалтын авлагаөөрчлөгдөхөдцэвэр нөөцийн холбогдох бүлэгт тусгадаг тул авлага нэмэгдэхэд кредит бичилтийг, буурахад дебет бичилтийг хийхгүй.

**1.1. Хөрөнгийн хувьцаа болон хөрөнгө оруулалтын санд хувь нийлүүлсэн хөрөнгө.**Хөрөнгийн өсөлтийг активын дебет бичилтээр, хөрөнгийн бууралтыг активын кредит бичилтээр харуулна. Хөрөнгийн авлага нэмэгдэх болон буурахад дараах бичилтийг хийнэ. Үүнд:

**Хөрөнгийн авлага нэмэгдэхэд**

Бичилт: дебет: санхүүгийн данс, багцын хөрөнгө оруулалт, актив, хөрөнгийн хувьцаа болон хөрөнгө оруулалтын санд хувь нийлүүлсэн хөрөнгө  
кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

**Хөрөнгийн авлага буурахад**

Бичилт: кредит: санхүүгийн данс, багцын хөрөнгө оруулалт, актив,хөрөнгийн хувьцаа болон хөрөнгө оруулалтын санд хувь нийлүүлсэн хөрөнгө  
дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

Мэдээллийн эх үүсвэр:Төв банкны дэлгэрэнгүй тайлан тэнцэл,гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн төлбөрийн тэнцлийн мэдээ, арилжааны банкуудын төлбөрийн тэнцлийн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа.

**1.2. Өрийн бичиг.** Тухайн улирлын эцэст харьяат бусаас авах авлагын нэмэгдсэн өөрчлөлтийг активын дебет бичилтээр, авлагын буурсан өөрчлөлтийг активын кредит бичилтээр тус тус харуулна. Өрийн бичгийн авлага нэмэгдэх болон буурахад дараах бичилтийг хийнэ. Үүнд:

**Өрийн бичгийн авлага нэмэгдэхэд**

Бичилт: дебет: санхүүгийн данс, багцын хөрөнгө оруулалт, актив, өрийн бичиг  
кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

**Өрийн бичгийн авлага буурахад**

Бичилт: кредит: санхүүгийн данс, багцын хөрөнгө оруулалт, актив, өрийн бичиг  
дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

Мэдээллийн эх үүсвэр:Төв банкны улирлын дэлгэрэнгүй тайлан тэнцэл, Гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн төлбөрийн

тэнцлийн мэдээ, арилжааны банкуудын төлбөрийн тэнцлийн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа.

2. **Пассив.**Пассив данс нь харьяат буст төлөх өглөгийг харуулна.Засгийн газар, Монголбанкны багцын хөрөнгө оруулалтынөглөг өөрчлөгдөхөдцэвэр нөөцийн холбогдох бүлэгт тусгадаг тул өглөг нэмэгдэхэд дебет бичилтийг, буурахад кредит бичилтийгхийхгүй.

- 2.1. **Хөрөнгийн хувьцаа болон хөрөнгө оруулалтын санд хувь нийлүүлсэн хөрөнгө.** Хөрөнгийн өсөлтийг пассивын кредит бичилтээр, бууралтыг пассивын дебет бичилтээр харуулна.Хөрөнгийн өглөг нэмэгдэх болон буурахад дараах бичилтийг хийнэ. Үүнд:

**Хөрөнгийн өглөг нэмэгдэхэд**

Бичилт: кредит: санхүүгийн данс, багцын хөрөнгө оруулалт, пассив, хөрөнгийн хувьцаа болон хөрөнгө оруулалтын санд хувь нийлүүлсэн хөрөнгө  
дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

**Хөрөнгийн өглөг буурахад:**

Бичилт: дебет: санхүүгийн данс, багцын хөрөнгө оруулалт, пассив,хөрөнгийн хувьцаа болон хөрөнгө оруулалтын санд хувь нийлүүлсэн хөрөнгө  
кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

Мэдээллийн эх үүсвэр:Гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн төлбөрийн тэнцлийн мэдээ, арилжааны банкуудын төлбөрийн тэнцлийн мэдээ, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн компанийн төвлөрлийн судалгаа, аж ахуйн нэгжийн судалгаа.

- 2.2. **Өрийн бичиг.**Харьяат буст өгөх өглөгийн нэмэгдсэн өөрчлөлтийг пассивын кредит бичилтээр, буурсан өөрчлөлтийг пассивын дебет бичилтээр бүртгэнэ.Өрийн бичгийн авлага нэмэгдэх болон буурахад дараах бичилтийг хийнэ. Үүнд:

**Өрийн бичгийн авлага нэмэгдэхэд**

Бичилт: дебет: санхүүгийн данс, багцын хөрөнгө оруулалт, пассив, өрийн бичиг  
кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, пассив, бэлэн мөнгө ба харилцах

**Өрийн бичгийн авлага буурахад**

Бичилт: кредит: санхүүгийн данс, багцын хөрөнгө оруулалт, актив, өрийн бичиг  
дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах

Мэдээллийн эх үүсвэр:Гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн төлбөрийн тэнцлийн мэдээ, арилжааны банкуудын төлбөрийн тэнцлийн мэдээ, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн компанийн төвлөрлийн судалгаа, аж ахуйн нэгжийн судалгаа.

### 4.3 Санхүүгийн үүсмэл хэрэгсэл болон албан хаагчдын үнэт цаасны опцион

Энэ бүлэгт харьяат ба харьяат бусын хооронд тодорхой нөхцөлтэйгөөр байгуулсан худалдах, худалдан авах гэрээ, хэлцэл (форвард, фьючерс, опцион, своп)-үүд болон түүнтэй адилтгах санхүүгийн хэрэгслүүдийг харуулна. Тус төрлийн гүйлгээг “санхүүгийн үүсмэл хэрэгсэл” болон “албан хаагчдын үнэт цаасны опцион” гэсэн 2

үндсэн төрлөөр, эдийн засгийн дөрвөн бүлгээр (Төв банк, Засгийн газар, Хадгаламжийн байгууллага ба Бусад сектор) ангилж бүртгэнэ.

“Санхүүгийн үүсмэл хэрэгсэл” гэж өөр төрлийн актив буюу үнэт цаас, түүхий эдийн үнэ, валютын ханш, хөрөнгийн зах зээлийн индекс зэргээс үнэ, ханш нь хамаарч байдаг, эрсдэлээс сэргийлэх зорилгоор худалдах, худалдан авах эрх олгосон санхүүгийн хэрэгслийг;

“Албан хаагчдын үнэт цаасны опцион” гэж ажил олгогчид тойгоокомпанийхаа үнэт цаасыг тодорхой үнээр, тодорхой хугацаандараа худалдаж авах хэлцэл хийхийг ойлгоно.

- 1. Актив.** Актив данс нь харьяат бусаас авах авлагыг харуулна. Засгийн газар, Монголбанкны санхүүгийн үүсмэл хэрэгслийн авлага өөрчлөгдөхөд цэвэр нөөцийн холбогдох бүлэгт тусгадаг тул авлага нэмэгдэхэд кредит бичилтийг, буурахад дебет бичилтийг хийхгүй. Актив дансны өсөлтийг дебет бичилтээр, бууралтыг кредит бичилтээр харуулна. Үүнд:

#### **Авлага нэмэгдэхэд**

Бичилт: дебет: санхүүгийн данс, санхүүгийн үүсмэл хэрэгсэл болон албан хаагчдын үнэт цаасны опцион (актив)  
кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах (бусад холбогдох данс)

#### **Авлага буурахад**

Бичилт: кредит: санхүүгийн данс, санхүүгийн үүсмэл хэрэгсэл болон албан хаагчдын үнэт цаасны опцион (актив)  
дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах (бусад холбогдох данс)

Мэдээллийн эх үүсвэр: Төв банкны дэлгэрэнгүй тайлан тэнцэл, гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн төлбөрийн тэнцлийн мэдээ, арилжааны банкуудын төлбөрийн тэнцлийн мэдээ, аж ахуйн нэгжийн судалгаа.

- 2. Пассив.** Пассив данс нь харьяат бусад төлөх өглөгийг харуулна. Засгийн газар, Монголбанкны санхүүгийн үүсмэл хэрэгслийн өглөг өөрчлөгдөхөд цэвэр нөөцийн холбогдох бүлэгт тусгадаг тул өглөг нэмэгдэхэд дебет бичилтийг, буурахад кредит бичилтийг хийхгүй. Пассив дансны өсөлтийг кредит бичилтээр, бууралтыг дебет бичилтээр харуулна. Үүнд:

#### **Өглөг нэмэгдэхэд**

Бичилт: кредит: санхүүгийн данс, санхүүгийн үүсмэл хэрэгсэл болон албан хаагчдын үнэт цаасны опцион (пассив)  
дебет: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах (бусад холбогдох данс)

#### **Өглөг буурахад:**

Бичилт: дебет: санхүүгийн данс, санхүүгийн үүсмэл хэрэгсэл болон албан хаагчдын үнэт цаасны опцион (пассив)  
кредит: санхүүгийн данс, бусад хөрөнгө оруулалт, актив, бэлэн мөнгө ба харилцах (бусад)



холбогдох данс)

Мэдээллийн эх үүсвэр: Гадаад гүйлгээний тайлан, аж ахуйн нэгжийн төлбөрийн тэнцлийн мэдээ, арилжааны банкуудын төлбөрийн тэнцлийн мэдээ, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн компанийн төвлөрлийн судалгаа, аж ахуйн нэгжийн судалгаа.

#### 4.4 Бусад хөрөнгө оруулалт

Энэ бүлэгт банкны харилцах, хадгаламж, худалдааны зээл, бусад төрлийн зээл, худалдааны санхүүжилт, санхүүгийн лизингийн эх үүсвэр болон бусад актив, пассивыг харуулна.

